



ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ЖАЙКА ОЛОН УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АСУУДАЛ: БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 2020

Мэдээллийн лавлах

Улаанбаатар хот  
2020 он

Copyright © 2020 by Ministry of Labor and Social Protection  
All rights reserved.

First Published 2020

Нүүрний зураг  
Зургийн нэр: Нар  
Зураач: Ж.Болор-Эрдэнэ  
(Дауны холбооны дэргэдэх Хөдөлмөр, сургалтын төвийн сурагч)

## ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b> .....	<b>5</b>
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД</b> .....	<b>8</b>
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА</b> .....	<b>11</b>
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН</b> .....	<b>20</b>
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ</b> .....	<b>23</b>
<b>ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ</b> .....	<b>33</b>
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНД</b> .....	<b>40</b>
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ</b> .....	<b>43</b>
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ: ХҮРТЭЭМЖ</b> .....	<b>50</b>
<b>ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЯАМДЫН ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ОНЦЛОХ АЖЛУУД</b> .....	<b>54</b>
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.....	54
Байгаль орчин, аялал жуулчлалын яам.....	57
Барилга, хот байгуулалтын яам.....	58
Батлан хамгаалах яам.....	60
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам.....	64
Зам, тээврийн хөгжлийн яам.....	66
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам.....	67
Хууль зүй, дотоод хэргийн яам.....	68
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.....	69
Эрүүл мэндийн яам.....	70
Эрчим хүчний яам.....	71
Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар.....	71
<b>АРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР</b> .....	<b>73</b>
1. Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллагын “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” (DPUB)..	73
2. Азийн хөгжлийн банкны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” ..	75
3. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв төсөл”, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар баригдах Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын төсөл.....	77
<b>ХАВСРАЛТ</b>	
Хавсралт 1 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он .....	78
Хавсралт 2 - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” .....	93
үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	
Хавсралт 3 - Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 111 дүгээр тогтоол .....	114
Хавсралт 4 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн тоо,	

насаар, төрлөөр, бэрхшээлийн хэлбэрээр .....	116
Хавсралт 5 - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд олгосон тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо, зарцуулсан хөрөнгө, 2019 он .....	119
Хавсралт 6 - Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн салбарт хамтран ажилладаг байгууллагуудын мэдээлэл .....	120
Хавсралт 7 - Монгол Улсын хөгжлийн бэрхшээлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын мэдээлэл.....	127

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон НҮБ-ын гишүүн орны хувьд тус конвенцийн үзэл баримтлалд тулгуурлан үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм зэргийг хүндэтгэсэн, эрхийг дээдэлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд Улсын Их Хурлаас батлан бусад холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Монгол Улсад Үндэсний статистикийн хорооны 2019 оны байдлаар 107,1 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдарч байна. Засгийн газар иргэн бүрийг хөгжлийн гадна үлдээхгүйн тулд бүтэц, тогтолцоогоо боловсронгуй болгох, олон нийтийн ойлголт, хандлагыг дээшлүүлэх, гадаад улс орон, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зэрэг чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэнийг дурдахад таатай байна.

Энэ хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах үндэсний зөвлөлийг 2016 оноос байгуулан ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг салбар бүрт ханган ажиллах, үндэсний зөвлөлд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий дэд болон салбар зөвлөл бүх яам, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллаж байна. Үүний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хариуцах асуудал гэсэн хандлага өөрчлөгдөж, салбар дундын асуудал, бүхий л салбарт хамааралтай гэдгийг ойлгож, салбар бүрт олон ажлыг санаачлан хийдэг болоод байна. Манай Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, тэднийг боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт гээд төрийн бүх үйлчилгээнд хамруулахыг зорьж байна. Иймд салбар дундын зохицуулалтыг бүрэн хийхийн тулд 2018 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болох Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг анх удаа байгууллаа. Манай улсад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, дэмжин хөгжихөд хувь нэмэр оруулдаг 600 гаруй төрийн бус байгууллага бий. Эдгээр төрийн бус байгууллагуудыг нэгтгэн нэгдсэн холбоо болгож зохион байгуулалтад оруулж эхэлсэн нь төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны зөв шийдлүүдийн нэг хэсэг гэж дүгнэж байна.

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн хамгааллын асуудалд ихээхэн анхаарч ажилласны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 15 нэр төрлийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийг нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас үзүүлж байна. Өнгөрсөн онд давхардсан тоогоор нийт 58,412 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулсан байгаагаас харахад ойролцоогоор 1 хүн 2 төрлийн арга хэмжээнд хамрагдаж байна. Ийнхүү Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын баталгааг хангах, орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн халамжийн арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүрийг хамруулж байгаа төдийгүй олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг байнга нэмэгдүүлэхэд анхаарч байна. Нийгмийн халамжийн сангаас олгодог нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ асардаг эцэг эхчүүдэд олгодог тэтгэмжийг нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинд хүргээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн асуудлаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эдгээр иргэдэд бусдын адил эрхээ эдэлж, сурч боловсрох, хөгжих, хөдөлмөрлөх, тэгш боломж олгох талаар Засгийн газраас хийх ажлыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөр” буюу дунд хугацааны бодлогын баримт бичигт тодорхойлоод байна. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийг 2019 онд ашиглалтад орууллаа. Мөн Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 6 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын барилгын ажлыг эхлүүлэхээр бэлтгэж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлан жил бүр 4,0 орчим тэрбум төгрөгний санхүүжилтийг олгож, 5000 гаруй хүнийг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байгаа арга хэмжээнд хамруулж байна.

Хөгжлийн бэрхшээлийн салбарт олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааг өргөжүүлж байна. Үүнд, Азийн хөгжлийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Хүн амын сан, Европын холбооны дэмжлэг, хамтын ажиллагааг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Өнгөрсөн жил 43 орны 700 гаруй хүнийг оролцуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн 4 дүгээр конгрессыг эх орондоо амжилттай зохион байгууллаа.

Түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан шийдвэрлүүлэх зэрэг эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эдийн засгийн бодлого нааштай үр дүнгээ өгч байгаа хэдий ч бидний өмнө хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ ажил, орлоготой байлгах, сурч боловсрох нөхцөлөөр бүрэн хангах, нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээний хүртээмж, хэмжээг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах нийгмийн хандлагыг эерэгээр өөрчлөх, тэдэнд тулгарч байгаа нийгмийн болон орчны саад бэрхшээл, ялгаварлан гадуурхалтыг арилгах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ёстой олон зорилт, шийдвэрлэх асуудал байгаа.

Тус яам, Японы олон улсын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, үр дүнг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах” товхимлоороо танилцуулдаг уламжлалтай.

Та бүхнийг энэхүү товхимлыг хүлээн авч, яамд, салбар бүрт 2019 онд хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авч, цаашдын үйл ажиллагаандаа ашиглана гэдэгт итгэлтэй байна.

Товхимлыг бэлтгэх, хэвлүүлж олны хүртээл болгоход дэмжлэг үзүүлж хамтран ажилласан бүх хүнд талархал илэрхийлье.

*ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА,  
“УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГМИЙН  
ОРОЛЦООГ ДЭМЖИХ ТӨСӨЛ”-ИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА*

*С.ТУНГАЛАГТАМИР*

## ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийн лавлах “Цагаан ном”-ын гурав дахь хэвлэлийг хэвлэн гаргасаж буй явдалд баяртай байна.

Эхний нэг, хоёр дахь хэвлэлд тус төслийн зүгээс хамтарч ажилласан бөгөөд гуравдахь хэвлэлийн хувьд DPUB төсөл зөвлөх байр сууринаас оролцож, ХНХЯ голлон санаачилж, хэвлэсэн болохыг зориуд тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу.

Мэдээллийн лавлах “Цагаан ном”-ын гол зорилго нь Монгол улсын засгийн газрын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон нийтэд түгээхэд оршино.

“Цагаан ном” -ыг хөгжлийн бэрхшээлтэй иргэний байгууллагууд болон засаг захиргааны байгууллагууд мэдээллийн цогц хэрэгсэл болгон түгээмэл ашигладаг хэмээн өндрөөр үнэлсэн байдаг.

Түүнчлэн 2019 оны 7-р сард зохион байгуулагдсан Ази номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамт олонд түшиглэн сэргээн засах IV конгресс (AP-CBID)-ийн үеэр тус “Цагаан ном”-ын Монгол, Англи хэл дээрх хувилбарыг оролцогчдод тараан сайн туршлага болгон, илтгэлийн үеэр танилцуулж, дотооддоо төдийгүй олон улсын төвшинд Монгол дахь үйл ажиллагааг ийнхүү үр дүнтэй сурталчилж чадсан нь бахархуштай.

Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төслийн хэрэгжих хугацаа 2020 оны 5-р сарын сүүлээр дуусах бөгөөд төсөл хэрэгжүүлэх явцын сүүлийн хамтын ажиллагаа нь энэхүү Цагаан номны гурав дахь хэвлэл болох хэдий ч, төсөл дууссаны дараа үргэлжлүүлэн хэвлэж, тухайн цаг үеийн шинэ мэдээллээр хангаж ажиллах нь нэн чухал гэж бодож байна. Энэхүү Цагаан номыг олон хүмүүс үргэлжлүүлэн ашиглах болно гэдэгт чин сэтгэлээсээ найдаж байна.

“Цагаан ном”-ыг хэвлэн гаргахад хүчин чармайлт гарган ажилласан Монгол улсын мэргэжилтэн албан тушаалтан, төслийн мэргэжилтнүүддээ гүнээ талархаж байгаагаа илэрхийлье.

*МОНГОЛ ДАХЬ ЖАЙКА ЯОУБ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ДАРГА  
ТАМУРА ЭРИКО*



## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

### **"Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн бүсийн IV конгресс"-ыг зохион байгууллаа.**

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор "Хэнийг ч орхигдуулахгүй байх" уриатай Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IV конгресс Улаанбаатар хотноо 2019 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Энэ удаагийн конгресст бүс нутгийн 34, бусад тивээс 9 орны нийт 700 гаруй төлөөлөгч оролцон "Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагаар дамжуулан тогтвортой нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих нь" сэдвээр хурал чууллаа. "Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эдийн засгийн хувьд эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа", "Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагын сайн туршлага", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог хангахад чиглэсэн Бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаа: 2015 оноос хойших ололт амжилт болон тулгарч буй бэрхшээл" гэсэн 3 сэдвээр нэгдсэн хуралдаан, 18 салбар хуралдаан хийж нийт 85 илтгэл хэлэлцэж, улс орнууд өөр өөрийн сайн туршлагаа хуваалцав.

Конгрессын зохион байгуулалтыг оролцогчид өндрөөр үнэлсэн бөгөөд Монгол Улс төр засгийн хэмжээнд анхаарал хандуулан Ерөнхий сайдынхаа ивээл дор зохион байгуулсан нь бүс нутгийн хэмжээнд сайн жишиг тогтоолоо хэмээн талархаж байсан. Зохион байгуулах хорооныхон энэ удаагийн конгресст өмнөх хурлуудыг бодвол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн идэвх, оролцоо өндөр байсан төдийгүй Монгол Улс өөрийн орны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулах тал дээр онцгой анхаарал тавьсныг онцолж байлаа.

Хуралд оролцогчид хөгжлийн бэрхшээлийн салбарын бодлого, хэрэгжилт, ололт амжилт, туршлага, сургамжийн талаарх мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн юм. Түүнчлэн цаашид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан томоохон арга хэмжээ эх орондоо зохион байгуулахад шаардлагатай хүртээмжтэй орчинг бүрдүүлж, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагч, иргэд, олон нийтийн хандлагыг өөрчлөхөд нөлөөлсөн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэхэд Засгийн газар нь манлайлан иргэд нь хүсэл, тэмүүлэлтэйгээр оролцож, иргэний нийгэм, хувийн хэвшил, олон улсын байгууллага, холбогдох бүх талуудын түншлэл, хамтын ажиллагаа, бүс нутаг, дэлхийн бүх улс орнууд хүчин чармайлтаа нэгтгэн ажиллах нь үр дүнтэй болохыг илтгэгч, оролцогчид онцлон тэмдэглэлээ. Манай орны хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөртөө туслах бүлэг байгуулан орлогоо хуримтлуулж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа туршлага маш чухал байлаа.

Энэхүү бүсийн чуулганыг Монгол Улсад зохион байгуулснаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа бүс, дэлхий нийтийн хэмжээнд сурталчилсан чухал арга хэмжээ боллоо.

Конгрессоор хэлэлцсэн асуудлаар "Улаанбаатарын тунхаглал"-ыг төлөөлөгчид батлан гаргасан нь бүс нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх чухал баримт бичиг болж буй юм. Дараагийн буюу V конгрессыг 2023 онд зохион байгуулах эрхийг Камбож улс авсан.





**“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн  
засах хөгжлийн төв” –ийг байгуулав.**

БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн барилгыг 2019 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар хүлээн авсан. Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 125 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийг байгуулж, дүрмийг баталлаа. Төв нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, сэргээн засах, хоёрдогч хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хамт олонд түшиглэн хөгжүүлэх, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. 250 ортой, 6 тасагтай стационари, оношилгоо шинжилгээ, сэргээн засах эмчилгээний төрөлжсөн кабинет бүхий амбулаторитой.

Төв нь Эрүүл мэндийн сэргээн засалтын, Боловсрол, нийгмийн сэргээн засалтын, Тусгай хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн, Захиргаа аж ахуйн гэсэн 4 газартай.

Өдрөөр 250, хэвтэн эмчлүүлэх 250 ортой, бүхий 6 тасагтай стационари, хөдөө орон нутаг, алслагдсан дүүргээс ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 14-21 хоног хэвтүүлэн нарийн мэргэжлийн болон орчин үеийн шинжилгээ, оношлогоо, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал, усан ба физик эмчилгээ зэрэг сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж, тохирох туслах хэрэгсэл / протез, ортопед/-ийг үйлдвэрлэнэ. Түүнчлэн шаардлагатай үед тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд холбогдох эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Тус төвийн амбулаторийн үйл ажиллагаа 2019 оны 06 дугаар сарын 01-нээс, Стационар /хэвтүүлэн эмчлэх/, өдрийн эмчилгээ болон лабораторийн үйл ажиллагаа 12 дугаар сарын 13-наас эхэлсэн юм. Амбулатороор 6-12 дугаар сарын хооронд 2000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.



## Монгол Улс “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтын Трейнер багшийг бэлтгэсэн 3 дахь орон боллоо

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран хэрэгжүүлж буй Япон улсын хамтын ажиллагааны “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг 4 дэх жилдээ зохион байгуулж байна.

Энэ хүрээнд 2016-2019 оны хооронд 3 удаагийн сургалтаар, нийтдээ 46 Сургагч багшийг бэлтгэлээ. Сургагч багш нарыг чадавхжуулах ажлыг тасралтгүй зохион байгуулж, сургагч багш нараас 11 хүнийг Ахлах сургагчаар, 3 хүнийг Трейнер багшаар бэлтгэлээ. Ийнхүү трейнер багштай болсноор Монгол Улс DET сургагч багшийг үндэсний багш нар өөрсдөө бэлтгэх боломжтой 3 дахь орон болоод байна. Сонирхуулахад Япон 2, Малайз улсад 4 трейнер багш байдаг юм байна. DET сургалтыг Монгол Улс 2017 оны 2 дугаар сараас албан ёсоор зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сарын сүүлийн байдлаар 306 удаагийн сургалтад нийт 10,140 хүнийг хамруулаад байна. Уг сургалтад хамрагдсан хүний тоогоороо манай улс дэлхийд тэргүүлж байна.

“Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг монголд нутагшуулах, сургалтын үйл ажиллагааг тогтмолжуулж, бэлтгэгдсэн сургагч багш нарыг чадавхжуулах зорилгоор DET Сургагч багш нар санаачлан 2017 оны 8 дугаар сард “DET Форум Монгол” ТББ-ыг байгуулж, албан ёсоор бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байна.



## ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

### 1. УДИРТГАЛ

Энэхүү бүлэгт хөгжлийн бэрхшээлийн статистикийн талаарх хууль эрх зүйн орчин, зорилго, ач холбогдлын талаар танилцуулах юм.

#### 1.1 Бодлого, хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Их Хурал Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1990 онд, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг 2008 онд тус тус соёрхон баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн эрхийг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээж байгаа билээ. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”, Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012-2022 зэрэг хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхээр үндэсний хэмжээнд шалгуур үзүүлэлтийн хүрээг бий болгох, тооцох, үнэлэхээр ажиллаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлийн статистикийн арга зүйг сайжруулах, олон улсад харьцуулагдахуйц тоо мэдээллийг бий болгох чиглэлээр НҮБ-ын дэргэдэх Вашингтон бүлгийн гишүүнээр идэвхтэй ажиллаж байна.

#### 1.2 Хөгжлийн бэрхшээлийн статистик гэж юу вэ?

Хөгжлийн бэрхшээл нь бүхий л байгууллагын үйл ажиллагаанаас хамаардаг салбар дундын асуудал юм. Уламжлалт ойлголтоор хөгжлийн бэрхшээлийн статистикийг “хараагүй”, “сонсголгүй”, “тэргэнцэртэй” зэрэг хүмүүсийг тоолох, тэдгээрт зориулсан нийгмийн халамжийн тэтгэмж, тусламжийг тодорхойлоход ашигладаг гэсэн ойлголт түгээмэл байв. Харин сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн өдөр тутмын амьдралд хүрээлэн буй орчны зүгээс тулгарч буй саад тотгор, тэдгээрийн аж амьдралын байдал, зорилтот үйл ажиллагаан дахь оролцоо, ялангуяа ажил хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, ялгаварлан гадуурхалт зэргийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зэрэг нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийг тусгасан өргөн агуулгаар хөгжиж байна. Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлийн статистик олон салбарын асуудлыг хэмжээсжүүлэн судалдаг шинжлэх ухаан юм.

Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлийн тархалтыг тодорхойлох зорилгоор мэдээллийг нэг хүнээс нийт хүн амд, тэдгээрийн нас, хүйс, арьс өнгө, нийгэм, эдийн засгийн байдал болон бусад онцлог шинж байдлаар нь боловсруулан гаргадаг юм.

#### 1.3 Хөгжлийн бэрхшээлийн статистикийн зорилго, ач холбогдол

Хөгжлийн бэрхшээлийн статистикийн зорилгыг өргөн хүрээгээр харахад тухайн улс орон нь конвенц, зөвлөмж, амлалтын хэрэгжилтийг хянах, үнэлэлт дүгнэлт өгөх, үнэн бодитой мэдээлэлд үндэслэн бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардлагатай тоо мэдээлэлтэй болгоход чиглэж байна. Энэ утгаараа хөгжлийн бэрхшээлийн статистик нь бүхий л салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах болон үр ашгийг үнэлэх, өртөг-үр ашгийн шинжилгээ хийх зэрэгт чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх үндэсний статистик, мэдээллийн нэгдсэн сан нь бодлогын асуудалд дараах чухал ач холбогдолтой юм. Үүнд:

- НҮБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” конвенц, холбогдох хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, стандарт дүрмийн хэрэгжилтийг хянах
- Үйлдлийн талаарх мэдээлэл (Functional status data) нь хэрэгцээг тодорхойлох, өөрөөр хэлбэл, ижил төрлийн гэмтэл согогтой хоёр хүний хувьд тодорхой үйл ажиллагааг эрхлэхэд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг тул тэдэнд тохирсон арга хэмжээг тодорхойлох
- Үйлдлийн талаарх мэдээллийг ашиглан хөдөлмөр эрхлэлт, боловсролын талаарх бодлого, хууль тогтоомжийг боловсруулах техникийн дэмжлэг үзүүлэх хэрэгцээг тодорхойлох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан бодлогын чанар, үр дүнг хянахад чухал үүрэгтэй. Ялангуяа эдгээр мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн амьдралын бүхий л салбарт тээвэр, харилцаа холбоо, шашин шүтлэг, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх бодлогын үр дүнг тодорхойлоход тусалдаг.

### 2. АРГА ЗҮЙ

Энэ хэсэгт хөгжлийн бэрхшээлийн статистик мэдээллийг цуглуулж буй эх үүсвэр, үндсэн үзүүлэлтийн талаарх ойлголт, тодорхойлолт, арга зүйтэй холбоотой мэдээлэл багтсан болно.

## 2.1 Мэдээллийн эх үүсвэр

Дэлхийн улс орнууд 18 дугаар зууны эхэн үеэс хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээллийг цуглуулж эхэлсэн түүхтэй. Сүүлийн 60 гаруй жилд энэ төрлийн мэдээллийг цуглуулах улс орны тоо нэмэгдэж, одоогийн байдлаар дэлхийн 198 улс орон давхардсан тоогоор 700 гаруй төрлийн тооллого, судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг цуглуулж байна<sup>1</sup>. Тухайлбал, АНУ, Энэтхэг, Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын асуулганд хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан байдаг.

Олон улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлийн статистикийн тоо мэдээллийг цуглуулахдаа хүн амын тооллого, түүвэр судалгаа (нийгмийн салбарын нийтлэг судалгаа, эрүүл мэндийн болон хөгжлийн бэрхшээлийн тусгайлсан судалгаа), захиргааны бүртгэл гэсэн гурван үндсэн эх үүсвэрийг ашиглаж байна.

Манай улсын хувьд уг статистикийн тоо мэдээллийг боловсруулахад дараах эх үүсвэрийг ашиглаж байна (Хүснэгт1). Үүнд:

i. Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1): нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харуулсан жил бүрийн мэдээлэл юм. Энэхүү мэдээнд эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөдөлмөрийн чадвараа тодорхой хувь хэмжээгээр алдаж, хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүмүүсийг хамруулдаг. Статистикийн үйл ажиллагааг эрхлэн явуулах анхан шатны нэгж буюу баг, хорооны Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газар, дүүрэг, аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар нь Нийгмийн зарим үзүүлэлтийн тухайн жил (тайлант хугацаа)-ийн мэдээллийг батлагдсан маягтын дагуу жил бүрийн 12 дугаар сард цуглуулан дамжуулж, Үндэсний статистикийн хороо уг мэдээллийг дараа жилийн 1 дүгээр сард нэгтгэн боловсруулж, хэрэглэгчдэд тархааж байна.

ii. Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцлийн үзүүлэлтийг цогцоор тодорхойлон судлах зорилгоор Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нийтэд тархаасан юм. 2020 оны Хүн ам орон сууцны тооллогын мэдээллийг цуглуулахдаа нийт өрхийн 10 хувийн мэдээллийг дэлгэрэнгүй цаасан асуулгыг, үлдсэн 90 хувийн мэдээллийг богино асуулга буюу интернэт, төрийн байгууллагын мэдээллийн сангуудын мэдээллийг ашигласан юм. Ингэхдээ зөвхөн цаасан асуулгад Вашингтон бүлгийн богино багц асуултыг шинээр оруулж, хүн амын үйлдлийн хүндрэлийн чадварын түвшинг тодорхойлж гаргах гэж байна.

iii. Өрхөд суурилсан түүвэр судалгаа нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөөлж болохуйц тодорхой хэсгийг сонгон авч дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар бодлого хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход ашиглаж байна. Үндэсний статистикийн хороо нь тогтмол хугацааны давтамжтайгаар өрхөд суурилсан түүвэр судалгааг зохион байгуулдаг бөгөөд эдгээр судалгаанд тодорхой зорилго, агуулгын хүрээнд боловсруулсан арга зүйг ашигладаг. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Ажиллах хүчний судалгаа, Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, Цаг ашиглалтын судалгаа зэрэг үндэсний хэмжээний төлөөллийг хангахуйц өрхөд суурилсан түүвэр судалгааны асуулгад хөгжлийн бэрхшээлийн талаарх асуултыг оруулж, мэдээллийг цуглуулж хэвшээд байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан бүрдүүлэх улсын үзлэг, тооллогын бэлтгэлийг бүрэн хангах зорилгоор Баян-Өлгий, Ховд аймагт туршилтын тооллого, судалгааг 2018 онд зохион байгуулсан бөгөөд энэхүү туршилтын тооллогод НҮБ-ын Хүүхдийн сан, Вашингтон бүлгийн хамтран боловсруулсан 5 хүртэлх насны хүүхдийн үйлдлийн чадвар алдалтыг тодорхойлох модуль асуулгыг ашигласан юм (ХҮСНЭГТ 1).

---

1. Washington group: History of disability measurement and data availability

Хүснэгт 1. Мэдээллийн эх үүсвэр, төрлөөр

<b>АЛБАН ЁСНЫ СТАТИСТИК</b> (ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО ХАРИУЦАН ГАРГАЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ)			<b>ЗАХИРГААНЫ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ</b> (САЛБАРЫН ЯАМДЫН ХАРИУЦАН ГАРГАЖ БУЙ МЭДЭЭЛЭЛ)	
ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ ТООЛЛОГО (10 жил тутам)			<b>ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ</b>	
ХҮН АМ, ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САН (жил тутам)			Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл (сар, жил)	Нийгмийн халамжийн сангийн мэдээлэл (сар, жил)
НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН МЭДЭЭ (жил тутам)			Мэргэжлийн болон техникийн боловсролын статистикийн мэдээ (жил)	
<b>ӨРХӨД СУУРИЛСАН ТҮҮВЭР СУДАЛГАА</b>			<b>ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ</b>	
Өрхийн Нийгэм, Эдийн Засгийн Судалгаа (2 жил тутам)			Эрүүл мэндийн статистикийн мэдээ (жил)	
Ажиллах хүчний судалгаа (улирал тутам)			<b>БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ</b>	
Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (5 жил тутам)			Сургуулийн өмнөх боловсролын статистикийн мэдээ (жил)	
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэг удаагийн бүртгэл, судалгаа (2004)			Ерөнхий боловсролын сургуулийн статистикийн мэдээ (жил)	
Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа (2017)				
Цаг ашиглалтын судалгаа (4 жил тутам)				
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх асуулгын ойлгомжтой байдлыг турших судалгаа (2009)				
Баян-Өлгий, Ховд аймагт зохион байгуулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн сан байгуулах туршилтын судалгаа (2018)				

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого, хөтөлбөр боловсруулах, тэдгээрийг үнэлж дүгнэхэд албан ёсны статистик буюу Үндэсний статистикийн хорооны Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээний үр дүнг голлон ашиглаж байна.

Дараах захиргааны бүртгэл, мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргаж байна. Үүнд: Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон хүүхэд, насанд хүрэгчид, цэцэрлэг, сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүх шатны эмнэлэгт хандаж эмнэлгийн үйлчилгээ авсан, нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн мэдээлэл зэрэг болно.

## 2.2 Хөгжлийн бэрхшээлийн ойлголт, тодорхойлолт

Олон арван жилийн туршид хөгжлийн бэрхшээлийг зөвхөн анагаах ухааны талаас нь тодорхойлдог байсан бол одоо нийгмийн амьдралд оролцох талаас нь авч үздэг болоод байна. Нийгмийн шинжлэх ухаанд хэрэглэдэг болон бусад тодорхойлолтод ажил, хөдөлмөр эрхлэх чадваргүй байдлыг харуулах эдийн засгийн загвар, хүмүүс өөрийн хөгжлийн бэрхшээлтэй байдалд сэтгэл зүйн талаас хандах байдлыг харуулсан зан суртахууны загвар зэргийг авч үздэг байна. Олон улсын байгууллагууд хүний эрхийн талаас нь илүү авч үзэн тодорхойлж байна. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө бүрэн, адил тэгш эдлэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих”-ийг хүлээн зөвшөөрчээ. Энэ агуулгаараа уг конвенц хөгжлийн бэрхшээлийг дан ганц нийгмийн хамгааллын бус, хүний эрхийн болон хууль эрх зүйн асуудал гэж тодорхойлсон байна. Иймээс энэхүү баримт бичигт ялгаварлан гадуурхалтын эсрэг, адил тэгш боломж, идэвхтэй оролцооны арга хэмжээ зэрэг гол элементүүдийг багтаасан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхүүд нь хөдөлмөр эрхлэлт, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бодлогын бүх салбаруудыг хамаарч байгаа юм<sup>2</sup>.

### 2.2.1 НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тодорхойлсон нь

НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүнийг “Бие махбодь, сэтгэл мэдрэл, оюун ухааны болон мэдрэхүйн согогтой, бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн үр бүтээлтэй оролцоход нь саад тотгор учирч буй хүмүүс” гэж тодорхойлсон байна.

### 2.2.2 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын түвшинд хэрэглэдэг ангилал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас (ДЭМБ)-аас гаргасан “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF)-д бие махбодын (физиологийн), сэтгэл зүйн үйлдэл болон биеийн бүтцийг хооронд нь тодорхой ялгаж заагласан байдаг. Уг ангилалд үйл ажиллагааны нөлөөлөл бүхий дараах 9 хүрээг дурдсан байдаг. Үүнд:

1. Сурах ба мэдлэгийг хэрэглэх (Learning and applying knowledge)
2. Нийтлэг үүргүүд ба хэрэгцээ, шаардлагууд (General tasks and demands)
3. Харилцаа (Communication)
4. Бие махбодын хөдлөх чадвар (Mobility)
5. Өөртөө тавих анхаарал халамж (Self-care)
6. Ахуйн амьдрал (Domestic life)
7. Хүмүүс хоорондын бие биендээ харилцан нөлөөлөх байдал болон харилцан хамаарал (Interpersonal interactions and relationships)
8. Амьдрах орчин (Major life areas)
9. Олон нийт, нийгэм ба иргэний амьдрал (Community, social and civic life)

### 2.2.3 Вашингтон бүлгийн арга зүй

Вашингтон бүлэг нь хөгжлийн бэрхшээлийн хэмжигдэхүүнийг олон улсын түвшинд харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2001 онд байгуулагдсан. Энэ зорилгын хүрээнд уг бүлэг нь хүн амын үйлдлийн чадварын хүндрэлийг тодорхойлох богино болон өргөтгөсөн багц асуултуудыг боловсруулж, өрхөд суурилсан түүвэр судалгаа, хүн амын тооллогын асуулгад ашиглаж, мэдээлэл цуглуулахыг зөвлөмж болгосон байдаг. Богино багц асуулга нь харах, сонсох,

---

2. Кристофер Касобон, НҮБХХ-ийн зөвлөх, “Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эдийн засаг, нийгмийн оролцоог сайжруулах нь: Өнөөгийн нөхцөл байдал ба хэтийн төлөв”, 2010 он



алхах, танин мэдэх, өөртөө анхаарал, халамж тавих, харилцан мэдээлэл солилцох гэсэн 6 багц үйлдлийн хувьд хүндрэлийг тодорхойлох бөгөөд “бэрхшээлгүй”, “бага зэрэг бэрхшээлтэй”, “маш их бэрхшээлтэй”, “огт чадахгүй” гэсэн 4 төрлийн хариулттай юм. Вашингтон бүлгийн стандартын дагуу дээрх 6 үйлдлийн дор хаяж нэг үйлдлийн хувьд “маш их бэрхшээлтэй” эсвэл “огт чадахгүй” гэж хариулсан хүнийг үйлдлийн чадвар алдалттай гэж тодорхойлж авч үзэхийг зөвлөмж болгосон байдаг.

2.2.4 Монгол Улсын “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулинд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тодорхойлсон нь

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулан ойлгоно” гэж заасан байдаг.

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу “Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ”-гээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээс хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгааныг тодруулах зорилгоор төрөлхийн эсвэл олдмол гэсэн шалтгаанаар авч судалж байна. Удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, харин ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, ердийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг олдмол хөгжлийн бэрхшээлтэй гэж ангилан авч үзэж байна.

Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа үндсэн шалтгааныг тодруулснаар урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотойгоор харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна. Үүнд:

- Харааны бэрхшээлтэй-харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “харах” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Ярианы бэрхшээлтэй- хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний “ярих” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Сонсголын бэрхшээлтэй- сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний “сонсох” хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг;
- Хөдөлгөөний бэрхшээлтэй- биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадваргүй хүнийг;
- Сэтгэцийн бэрхшээлтэй- сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан хүнийг;
- Хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй- нэг хүнд нэгээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдсон хүн, Тухайлбал: сэтгэцийн, хөдөлгөөний, ярианы бэрхшээлтэй байж болно гэх мэт;
- Бусад хэлбэрийн бэрхшээлтэй- ямар нэгэн эмгэг болон өвчний улмаас өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа алдсан хүнийг, тухайлбал, дотор эрхтний эмгэгүүд хавдар гэх мэт хамруулна.


### 3. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ТЭДГЭЭРИЙН АШИГЛАЛТ

Энэхүү бүлгээр хөгжлийн бэрхшээлийн албан ёсны статистикийн мэдээний үр дүнгийн боломжит мэдээлэл болон 2018 онд зохион байгуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнг хураангуйлан танилцуулж байна. Өмнө бүлгийн “2.1 мэдээллийн эх үүсвэр” хэсэгт дурдсанаар Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ болон Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа нь хоёулаа хөгжлийн бэрхшээлийн статистикийн албан ёсны статистикийн мэдээллийн үүсвэр юм.

### 3.1 Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээний үр дүн

Албан ёсны статистик (Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ)-ийн 2019 оны мэдээллээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 107.1 мянгад хүрч өмнөх онтой харьцуулахад 1.3 мянга (1.3%)-аар, 2010 онтой харьцуулахад 24.4 мянга (29.6)-аар нэмэгджээ.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хүйсээр, мян.төг



Эх үүсвэр: Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлгээр ангилан харахад 20-34 насныхан 21.7 мянга (20.2%), 35-64 насныхан 64.4 мянга (61.1%) байна. Хүснэгт 2-т харуулснаар насны бүлэг ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо (65 ба түүнээс дээш насыг оруулахгүйгээр) нэмэгдэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаас илүү хувь нь эрэгтэйчүүд байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насны бүлэг, хүйсээр, 2019 он

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Хүний тоо	Дүнд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>107 075</b>	<b>100.0</b>	<b>61 095</b>	<b>100.0</b>	<b>45 980</b>	<b>100.0</b>
0-4	1 976	1.8	1 193	2.0	783	1.7
5-9	3 727	3.5	2 222	3.6	1 505	3.3
10-14	3 794	3.5	2 215	3.6	1 579	3.4
15	672	0.6	420	0.7	252	0.5
16	688	0.6	402	0.7	286	0.6
17	749	0.7	412	0.7	337	0.7
18	870	0.8	544	0.9	326	0.7
19	1 085	1.0	667	1.1	418	0.9
20-34	21 668	20.2	12 427	20.3	9 241	20.1
35-64	65 487	61.2	37 276	61.0	28 211	61.4
65, түүнээс дээш	6 359	5.9	3 317	5.4	3 042	6.6

Эх үүсвэр: Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)

2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 56.7 хувь нь олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болсон байхад 43.3 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй гэж мэдээлжээ (Хавсралт ХҮСНЭГТ 2). Энэхүү үзүүлэлтийг насны бүлгээр ангилахад бага, залуу насныхны дүнд



төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага ажиглагдаж байна (Зураг 2).


Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насны бүлэг, төрлөөр, 2019 он



Эх үүсвэр: Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)

Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой байна. Сүүлийн 7 жилийн мэдээллээс харахад олдмол хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийн дийлэнх буюу 70.0 орчим нь хувь нь ердийн өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж байна. Мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн эзлэх хувь 2019 оны байдлаар 5.8 болж, 2013 оныхоос 4.2 пунктээр, өмнөх онтой харьцуулахад 1.3 пунктээр буурчээ. Мөн ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа хүмүүсийн хувь буурах хандлагатай байна. Харин зам тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэдийн эзлэх хувь 2019 онд 4.3 болж 2013 оныхоос 0.3 пунктээр нэмэгдэж, өмнөх оныхоос 0.1 пунктээр буурсан байна.

Зураг 3. Олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд, дүнд эзлэх хувь, шалтгаанаар




Эх үүсвэр: Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)

2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 34.9 мянга (32.6%) иргэд Улаанбаатар хотод байгаа нь хамгийн их, харин 10.1 мянган (9.5%) иргэд зүүн бүсэд байгаа нь хамгийн бага байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь Увс аймагт 4.4, Хөвсгөл аймагт 5.6, Сэлэнгэ аймагт 4.6, Дорнод аймагт 4.0 байгаа нь бүс тус бүрийн хувьд хамгийн их байна (ХАВСРАЛТ Хүснэгт 4.2) Хөгжлийн бэрхшээлтэй 5 хүн тутмын нэг нь хөдөлгөөний, 10 хүн тутмын нэг нь харааны бэрхшээлтэй байна. Харин ярианы бэрхшээлтэй иргэд хамгийн бага буюу 3.8 хувийг эзэлж байна. Энд бусад хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хамгийн их хувийг эзэлж байгаа нь одоо мөрдөгдөж байгаа хөгжлийн бэрхшээлийн 6 хэлбэрийн ангиллыг шинэчлэн боловсруулах, ялангуяа бусад хэлбэрийг задлах хэрэгцээ байгааг харуулж байна (ХАВСРАЛТ Хүснэгт 4.1).

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дүнд эзлэх хувь, хэлбэрээр



Эх үүсвэр: Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)

2019 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 33.0 хувь нь Улаанбаатар хотод байхад зүүн бүсэд хамгийн бага буюу 9.6 хувьтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь Увс аймагт 4.4, Хөвсгөл аймагт 5.7, Сэлэнгэ аймагт 4.7, Дорнод аймагт 4.1 байгаа нь бүс тус бүрийн хувьд хамгийн их байна (Хавсралт ХҮСНЭГТ2).

### 3.2 Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүн

Энэхүү судалгааны үндсэн зорилго нь үндэсний болон олон улсын түвшинд дэвшүүлсэн зорилт, амлалтын хэрэгжилтийг хянах, нотолгоонд суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулахад шаардлагатай олон улсын түвшинд харьцуулагдахуйц тоо мэдээллийг гаргахад оршиж байгаа юм. Хоёр дахь удаагийн судалгааг 2018 онд зохион байгуулсан бөгөөд 18-49 насны эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхэд, 5-17 насны хүүхдүүдийн үйлдлийн чадварын хүндрэлийн талаарх мэдээллийг Вашингтон бүлгийн стандарт асуулга, зөвлөмжийн дагуу анх удаа цуглуулж, үр дүнг тооцож 2019 онд танилцуулсан юм. Үйлдлийн чадварын хүндрэлийн хувийг тооцохдоо дор хаяж аль нэг үйлдлийн хувьд "маш их бэрхшээлтэй" эсвэл "огт чадахгүй" гэж хариулсан хүмүүсийг хамааруулсан юм. Судалгааны үр дүнгээр 18-49 насны эмэгтэйчүүдийн хувьд үйлдлийн хүндрэлийн хувь 6.1, энэ насны эрэгтэйчүүдийнх 8.5 хувь байна. 18-49 настай эрэгтэй, эмэгтэйчүүдийн харах үйлдлийн чадварын хүндрэл хамгийн их буюу 3.3 хувь байна.

Зураг 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүйс, хүндрэлийн хэлбэрээр



Эх үүсвэр: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

Судалгаанд хамрагдсан 2-4 настай хүүхдийн 1.9 хувь нь аль нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй байгаа бол 5-17 настай хүүхдийн хувьд 6.1 хувь, 2-17 настай хүүхдийн хувьд 5.1 хувь байна. Энэ үзүүлэлт нь аль ч насны бүлгийн эмэгтэй хүүхдийн хувьд эрэгтэй хүүхдийнхээс өндөр байна.

Хүснэгт 3. Үйлдлийн чадварын хүндрэлтэй 2-4, 5-17, 2-17 насны хүүхдийн хувь

	Аль нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй 2-4 насны хүүхдийн хувь	2-4 насны хүүхдийн тоо	Аль нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй 5-17 насны хүүхдийн хувь	5-17 насны хүүхдийн тоо	Аль нэг үйлдлийн чадварын хувьд хүндрэлтэй 2-17 насны хүүхдийн хувь	2-17 насны хүүхдийн тоо
Бүгд	1.9	3 794.9	6.1	12 272.7	5.1	16 067.6
Эрэгтэй	1.8	1 964.0	5.6	6 319.6	4.7	8 283.6
Эмэгтэй	2.0	1 830.8	6.5	5 953.1	5.5	7 784.0

Эх үүсвэр: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2018 он

#### 4. ДҮГНЭЛТ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Хөгжлийн бэрхшээлийн статистикийн сайжруулах чиглэлээр сүүлийн жилүүдэд нилээдгүй хүчин чармайлтыг гарган ажиллаж байна. Үүний тод жишээ бол тоо мэдээллийн олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Вашингтон бүлгийн стандарт богино асуулгыг Хүн ам орон сууцны тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаануудын асуулгад оруулж, мэдээллээ цуглуулж байна.

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг үзэл санаа өргөжин тэлж, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг өргөн агуулгаар хөгжиж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хөгжлийн бэрхшээлгүй иргэдтэй адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, тэдгээртэй ажил хөдөлмөр эрхэлж, ижил хөлс авах зэрэг үзэл санаанд үндэслэн хөгжиж байна. Үүнтэй уялдаж хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг сайжруулах хэрэгцээ шаардлага байсаар байна. Энэ хүрээнд:

- 1) Хөгжлийн бэрхшээлийн статистикийн ойлголт, нэр томъёоны хамрах хүрээг сайжруулах (Хүний эрхэд суурилсан хөгжлийн бэрхшээлийн статистикийг хөгжүүлэх).
- 2) Тоо мэдээллийн нэгдмэл байдлыг хангах, албан ёсны болон захиргааны мэдээлэл, цахим мэдээллийн сангуудын уялдааг хангах, статистикийн зорилгоор ашиглах боломжийг нэмэгдүүлэх, нэгдсэн мэдээллийн санг бий болгох хэрэгцээ байна.
- 3) Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнд үндэслэн зорилтот түүвэр судалгаа (follow-up) зохион байгуулахаар төлөвлөж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүрээлэн буй орчинд тулгарч буй саад тотгор, бэрхшээл, түүний шалтгааныг тодруулан судлах, мөн тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход чиглэсэн тоон болон чанарын судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэн хөгжүүлж, тэдэнд чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээг зөв оновчтой төлөвлөхөд ашиглах
- 4) Олон улсын ангиллыг үндэсний онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх, мөн үндэсний хэмжээнд мөрдөх ангилал, кодын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, хянах болон тоо мэдээллийн олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх
- 5) Дэлхийн болон үндэсний тогтвортой хөгжлийн зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох, тайлагнах
- 6) Инчеоны стратегийн хэрэгжилтийг үнэлэх үндэсний үзүүлэлтийн хүрээг тогтоох, тооцох
- 7) Тоо мэдээллийн хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх буюу ялангуяа харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх
- 8) Хөгжлийн бэрхшээлийн статистикийн тоо мэдээллийн үр нөлөөг нэмэгдүүлэх нь чухал байна. Ялангуяа хэрэглэгчдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх улмаар мэдээллийн ашиглалтыг нэмэгдүүлэх
- 9) Хөгжлийн бэрхшээлийн статистик нь олон хэмжээст ойлголт учраас салбар бүрийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэх, оролцоог хангасан байдлаар үндэсний, бүсийн, олон улсын сургалт, семинар, уулзалт, хурлыг тогтмол зохион байгуулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

### Холбогдох бодлого, хууль тогтоомж

#### 1. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

(Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан)

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмын хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ” гэж заасан.

#### 2. Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого

(Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан)

Тус бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчин бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршиж байна.

Бодлогод

4.1. “Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.1.14. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах, хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх;

4.1.15. хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх;

4.3. “Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах” чиглэлээр:

4.3.8. олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх;

4.3.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох;

4.4. “Хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.4.5. хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай иргэдийн боловсролын хэрэгцээг хангах, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах орчныг бүрдүүлэх;

4.5. “Хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.5.1. байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг урамшуулах;

4.5.5. эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх талаар тусгасан байна.

#### 3. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална;

3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна;

3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж заасан.

#### 4. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” 2018~2022 он

Тус үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн

хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/116, А/304, А/197 тоот хамтарсан тушаалаар батлууллаа. / Хөтөлбөрийн төлөвлөгөөг хавсралт 2-оос үзнэ үү./

5. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр”

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтлах зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино.

6. Олон улсын баримт бичиг:

- Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ 1989 он
- Саламанкагийн тунхаглал “Тусгай хэрэгцээт боловсролын талаар гаргасан баримт бичиг”, 1994 он
- Дакарын үйл ажиллагааны хүрээ “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг”, 2000 он
- “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал)” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2001 он
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан бичиг баримт” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2004 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, НҮБ 2006 он
- “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын удирдамж” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон улсын консорциум, 2010 он
- “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк, 2011 он
- Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал”, 2012 он
- Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012 он

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг тусгасан Монгол Улсын хууль:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016 он
  - Хөдөлмөрийн тухай хууль, 1999 он
  - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011 он
  - Нийгмийн даатгалын тухай хууль, 1994 он
  - Нийгмийн халамжийн тухай хууль, 2012 он
  - Боловсролын багц хууль, 2002 он
  - Барилгын тухай хууль, 2016 он
  - Эрүүл мэндийн тухай хууль, 2011 он
  - Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 он
  - Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2015 он
  - Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008 он
  - Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, 2006 он гэх мэт
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар:
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудлыг хариуцсан байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, хууль хоорондын нийцлийг хангах, Хөгжлийн бэрхшээлтэй хүний

эрхийн тухай хуулийн дагуу батлан мөрдүүлэх боловч батлагдаагүй 15 журмаар зохицуулах шаардлагатай зарим харилцааг салбар хуулиар зохицуулахаар тусгах, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог сайжруулах, зарим нэр томъёог олон улсын гэрээнд нийцүүлэн өөрчлөх зэрэг асуудлыг шийдвэрлэх юм.

- Хөдөлмөрийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн харилцааны зарим онцлог зохицуулалтыг заасан. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор ажлын байрны квотыг тогтоож, 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага ажлын байрныхаа 4 ба түүнээс дээш хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн нөхцөлийн харгалзан долоо хоногт 36 цаг хүртэл байхаар зохицуулсан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан.

- Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 3 дугаар сард УИХ-д Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн барьсан. Уг хуулийн төсөлд ажлын байрны квотын зохицуулалтаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, шаардлагатай тохиолдолд өөртэй нь тохиролцох замаар ажлын байрыг өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан ажил олгогчийг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалтыг тус тус тусгасан. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхахыг хориглож, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь цалин хөлсийг бууруулах үндэслэл болохгүйг шинээр нэмж тусгаад байна.

- Нийгмийн халамжийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нийгмийн халамжийн тэтгэвэр авдаг хөдөлмөрийн чадвараа 50-69 хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөр эрхлэх бодлогоор дэмжих, харин 70 ба түүнээс дээш хувиар алдсан иргэнд жилд нэг удаа олгодог түлээ нүүрс, орон сууцны хөнгөлөлтийг нийгмийн халамжийн тэтгэвэртэй нэгтгэж, тэдний тэтгэврийн хэмжээ нийгмийн халамжийн бусад тэтгэврийн хэмжээнээс 20 хувиар илүү байхаар.

- Халамжийн үйлчилгээнд одоо үзүүлж байгаа хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээ хамаарахаар тусгаж, харин хөгжлийн үйлчилгээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр төрлийг өөрчлөн сайжруулж, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх шинэ үйлчилгээг бий болгон хамрагдаж байгаа халамж хүртэгч иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан дэмжлэг үзүүлэх зэргийг тусгахаар зохицуулсан.

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа” гэсэн тусгай бүлэг нэмж, зохицуулалтыг илүү нарийн болгохоор ажиллаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажилд зуучлах үйлчилгээг сайжруулах, үүнд тэдний эрх ашгийн төлөөх төрийн бус байгууллагыг татан оролцуулах талаар тусгаад байна.

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Даатгуулагчид нийгмийн даатгалын нэг төрлийн сангаас тэтгэвэр буюу тэтгэмжийг давхардуулж олгохгүй. Хэрэв давхардахаар байвал даатгуулагч илүү таатай нөхцөлтэй тэтгэвэр буюу тэтгэмжийг зөвхөн нэг удаа сонгон авах эрхтэй” гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

- Дээрх хуулийн дагуу нийгмийн даатгалын сангаас, эсхүл нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болон шимтгэл төлсөн байвал зохих хугацааны болзлыг хангасан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин өндөр насны тэтгэвэр нь тахир дутуугийн тэтгэврээс бага тогтоогдох тохиолдолд өөрт илүү таатай тэтгэврийн төрлийг сонгон авах боломжийг хуулиар зохицуулсан болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

### Нийгмийн даатгал

#### 4.1. Хууль тогтоомж:

Нийгмийн даатгалын дараах хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
- Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль;

#### 4.2. Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нь:

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс даатгуулагч /иргэн/-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог байгууллага юм.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс, нь даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг мэргэжлийн түвшинд тогтоох үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын зорилго нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас иргэн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас /хэсэгчлэн/ алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх зорилготой юм.

Комиссын бүрэлдэхүүнд аймаг, дүүргийн (2 дахь шатлал) эмнэлгийн эмч мэргэжилтэн оролцуулсан 7-9 хүнээс бүрдэх ба дотор, мэдрэл, мэс заслын эмч, нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нийгмийн даатгалын хэлтсийн дарга, нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, ажил олгогчийн төлөөлөл, даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

Харин Төв комиссын бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн шинжээч эмч нар, ажил олгогчийн төлөөлөл 15 хүнтэй байна.

Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг бүрэн алдсан буюу 70-аас дээш хувь, хагас алдсан буюу 50-69 хувиар алдсан гэж 2 ангилдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар “0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тодорхойлно” гэж заасны дагуу аймаг, дүүрэг бүрт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү комисс нь 0-16 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлон, байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тогтоон эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц хөтөлбөрт хамруулах ажлын зохион байгуулж байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо 2019 онд 111386 байгаа нь нийт хүн амын 3.5 хувийг эзэлж байна. Үүнээс дотор, сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, гэмтэл согогийн өвчин, нүдний өвчин нь хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж байгаа ба нийт хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн 76.01 хувийг эзэлж байна.

#### 4.3. Нийгмийн даатгалын үйлчилгээний төрөл:

Даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг дараах даатгалын төрлөөс олгож байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал;
- Тэтгэмжийн даатгал;
- Ажилгүйдлийн даатгал;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;
- Эрүүл мэндийн даатгал.

4.3.1.Өндөр насны тэтгэвэр:

Даатгуулагч нь нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 65 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.Тэтгэврийн насны эрэгтэй 60, эмэгтэй 55 нас, 2018 оноос жил бүр 6 сараар 3 насаар нэмэгдүүлэх замаар тэтгэвэр тогтоолгох насыг эрэгтэй, эмэгтэй хүний хувьд адилхан 65 болгох юм. 2018 оноос өндөр насны тэтгэврийн насыг тухайн даатгуулагчийн төрсөн оноос хамаарч жил бүр 3 сараар нэмэгдүүлэхээр болсон. Тухайлбал, эрэгтэй даатгуулагч 1958 онд төрсөн бол 60 нас 3 сартайдаа, 1959 онд төрсөн бол 60 нас 6 сартайдаа, 1960 онд төрсөн бол 60 нас 9 сартайдаа, эмэгтэй даатгуулагчийн хувьд 1963 онд төрсөн бол 55 нас 3 сартайдаа, 1964 онд төрсөн бол 55 нас 6 сартайдаа, 1965 онд төрсөн бол 55 нас 9 сартайдаа тус тус өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.



## Хүснэгт 4. Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх нас

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоох нас
1957 ба түүнээс өмнө	60 нас	1962 ба түүнээс өмнө	55 нас
1958	60 нас 3 сар	1963	55 нас 3 сар
1959	60 нас 6 сар	1964	55 нас 6 сар
1960	60 нас 9 сар	1965	55 нас 9 сар
1961	61 нас	1966	56 нас
1962	61 нас 3 сар	1967	56 нас 3 сар
1963	61 нас 6 сар	1968	56 нас 6 сар
1964	61 нас 9 сар	1969	56 нас 9 сар
1965	62 нас	1970	57 нас
1966	62 нас 3 сар	1971	57 нас 3 сар
1967	62 нас 6 сар	1972	57 нас 6 сар
1968	62 нас 9 сар	1973	57 нас 9 сар
1969	63 нас	1974	58 нас
1970	63 нас 3 сар	1975	58 нас 3 сар
1971	63 нас 6 сар	1976	58 нас 6 сар
1972	63 нас 9 сар	1977	58 нас 9 сар
1973	64 нас	1978	59 нас
1974	64 нас 3 сар	1979	59 нас 3 сар
1975	64 нас 6 сар	1980	59 нас 6 сар
1976	64 нас 9 сар	1981	59 нас 9 сар
1977 ба түүнээс хойш	65 нас	1982	60 нас
		1983	60 нас 3 сар
		1984	60 нас 6 сар
		1985	60 нас 9 сар
		1986	61 нас
		1987	61 нас 3 сар
		1988	61 нас 6 сар
		1989	61 нас 9 сар
		1990	62 нас
		1991	62 нас 3 сар
		1992	62 нас 6 сар
		1993	62 нас 9 сар
		1994	63 нас
		1995	63 нас 3 сар
		1996	63 нас 6 сар
		1997	63 нас 9 сар
		1998	64 нас
		1999	64 нас 3 сар
		2000	64 нас 6 сар
		2001	64 нас 9 сар
		2002 ба түүнээс хойш	65 нас

Даатгуулагч өөрөө хүсвэл доор дурдсан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан бол эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насанд хүрээд өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (20 жил)-г 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлсэн. Тухайлбал, даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 2018 онд 20 жил 3 сар, 2019 онд 20 жил 6 сар, 2020 онд 20 жил 9 сар, 2021 онд 21 жил байна.

Хүснэгт 5. Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа

Он	Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих хугацаа
2017	20 жил
2018	"20 жил 3 сар"
2019	"20 жил 6 сар"
2020	"20 жил 9 сар"
2021	21 жил
2022	"21 жил 3 сар"
2023	"21 жил 6 сар"
2024	"21 жил 9 сар"
2025	22 жил
2026	"22 жил 3 сар"
2027	"22 жил 6 сар"
2028	"22 жил 9 сар"
2029	23 жил
2030	"23 жил 3 сар"
2031	"23 жил 6 сар"
2032	"23 жил 9 сар"
2033	24 жил
2034	"24 жил 3 сар"
2035	"24 жил 6 сар"
2036	"24 жил 9 сар"
2037	"25 жил"

### Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл ( тооцох аргачлал )

Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж цалингийн 45 хувиар өндөр насны тэтгэврийг тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл олгоно.

Мөн тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлдэг.

Хувь тэнцүүлсэн тэтгэвэр

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас 20 хүртэл жил төлсөн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны болзол хангасан даатгуулагч шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгоно.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тогтоолгох тэтгэвэр

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан, дөрөв түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр;
- Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч

хуульд заасан шимтгэл төлөх хугацааны болзол хангасан тохиолдолд эрэгтэй 50, 55, эмэгтэй 45 нас хүрсэн бол,  
 - Нийт 20-иос доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол,  
 - 2/нийт 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй жил малчнаар ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол, тэтгэвэр тогтоолгох боломжтой.

### Тэтгэврийн нэмэгдэл

Монгол Улсын Засгийн газраас тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлээд байна.

Хүснэгт 6. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн байдал

№	Он	Бүрэн	Хувь тэнцсэн
1	2014	207300	172200
2	2015	230000	195000
3	2016	251000	216000
4	2018	280000	243000
5	2019	310000	270000
6	2020	350000	300000

### 4.3.2.Тахир дутуугийн тэтгэвэр

“Тахир дутуугийн тэтгэвэр” гэдэг нь ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа байнга, эсхүл удаан хугацаанд алдсан даатгуулагч иргэнд хуульд заасан шимтгэл төлөх болзлыг хангасан тохиолдолд түүний хөдөлмөрийн чадвар алдсан хугацаанаас эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тахир дутуугийн бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх:

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга, эсхүл удаан хугацаагаар алдсан;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн, эсхүл хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 5 жилийн дотор нийтдээ 36 сар буюу 3 жилд шимтгэл төлсөн байна.

Тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх:

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар тогтоолгосон байх;
- Нийтдээ 3-аас 20 хүртэл жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байх.

Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт материал

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр
- 1995 оноос өмнөх хугацаанд ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах, эсхүл архивын лавлагаа
- 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд батлагдсан маягтын дагуу тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагаар, эсхүл архивын сан хөмрөгөөс гаргуулсан лавлагаа
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр
- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- 2 хувь цээж зураг /3\*4 хэмжээтэй/

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон тахир дутуугийн тэтгэвэр авч буй иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бол авч буй сарын цалин, хөлснөөсөө тооцуулж нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлдөг бол тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хувьд сайн дураараа нийгмийн даатгалын шимтгэл төлөх эрх нь нээлттэй юм.

Хөдөлмөрийн чадвараа хагас болон бүрэн алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэн нийгмийн даатгалын сангаас, эсхүл халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон авч байх хугацаандаа ажил олгогч, иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ, түүнтэй адилтгах бусад гэрээний дагуу ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол нийгмийн даатгалд албан журмаар даатгуулдаг. Нийгмийн даатгалын тухай хуулинд заасны дагуу албан журмаар даатгуулж буй тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос дараах хувь хэмжээгээр тооцож шимтгэл ногдуулдаг:

### Нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах шимтгэлийн хувь хэмжээ

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчоос	Тэтгэвэр авагч даатгуулагчаас
Тэтгэврийн даатгал	8.5	8.5
Тэтгэмжийн даатгал	1	0.8
Эрүүл мэндийн даатгал	Төрөөс хариуцан төлнө	
Ажилгүйдлийн даатгал	-	-
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал /Зөвхөн ажил олгогч хариуцан төлнө/	0.8, 1.8, 2.8	-
Шимтгэлийн дүн	10.3-12.3	9.3

Сайн дураараа тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхдөө сарын орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, шимтгэл төлөх орлогын сарын дээд хэмжээнээс ихгүй байхаар өөрөө тодорхойлно. Ийнхүү хуульд заагдсан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас болон шимтгэл төлсөн байвал зохих хугацааны болзлыг хангасан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ. Тахир дутуугийн бүрэн тэтгэврийн доод хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 26 дугаар тогтоолоор 2019 оны 02 дугаар сараас эхлэн 310000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 270000 төгрөгөөр тогтоосон.

#### 4.3.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйлчилгээ

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзахгүйгээр тахир дутуугийн тэтгэврийг сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогоос даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтоож олгоно.

“Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу даатгуулагчид дараах тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг олгоно:

- 1/ тахир дутуугийн тэтгэвэр;
- 2/ тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- 3/ хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- 4/ хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр.
- 5/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл;
- 6/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын даатгуулагчийг сувилахад ногдох тусламж үйлчилгээний хувьсах зардал;
- 7/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагч нь рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд сувиллын зардал, ирж очих унааны зардлыг нийгмийн даатгалын байгууллагаас жилд нэг удаа хариуцан төлнө.

#### 4.3.4. Ажилгүйдлийн тэтгэмж

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай тушаал шийдвэр гарснаас өмнө нийтдээ 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлсөн бол ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ. Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

Уг тэтгэмжийг даатгуулагч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын хэлтэст бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно.

Тэтгэвэр авч буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд ажилгүйдлийн тэтгэмж тогтоолгон авах эрх үүсэхгүй. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй даатгуулагч ажил хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалд албан журмаар даатгуулахдаа хуульд заасны дагуу ажилгүйдлийн даатгалын санд шимтгэл төлдөггүй болно.

#### 4.3.5. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнөх 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах эрхтэй. Даатгуулагчийн шимтгэл төлсөн сарын дундаж орлогын хэмжээнээс шимтгэл төлсөн хугацаанд хамаарах /50, 55, 75/ хувиар тооцож хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр бодож олгоно. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсвэл тахир дутуугийн тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацаанд ажлын 66 өдрийн, хуанлийн жилд удаа дараа өвдвөл ажлын 132 өдрийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага олгоно.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дурын даатгуулагч эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг 70 хувиар боддог байсныг нэмэгдүүлж 100 хувиар бодож олгоно.

2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сайн дурын даатгуулагч эхийн нийгмийн даатгалын шимтгэлийг 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг даатгуулагч эх өөрөө төлөх, огт даатгуулж байгаагүй бол 50 хувийг нь улсын төсвөөс 50 хувийг өөрөө төлөх боломжтой болсон.

#### Тулгамдаж буй асуудлууд

Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж халдварт бус өвчнүүд, ахуйн ослоос шалтгаалсан хүн амын дундах өвчлөлийн түвшинг бууруулах хөдөлмөрийн чадвар алдахаас сэргийлэх, эрт илрүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч /иргэн/-ий эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах, эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нийгмийн бүхий л түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлж, боловсрол эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

#### Нийгмийн халамж

1. Холбогдох хууль тогтоомж
1. Нийгмийн халамжийн тухай хууль
2. Ахмад настны тухай хууль
3. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
5. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль
6. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль

#### Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж

##### 1) Нийгмийн халамжийн тэтгэвэр

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид "тэтгэвэр" гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгож байна.

Үүнд:

- Эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн
- 16 насанд хүрсэн одой иргэн;
- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд;
- 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 27 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэн сард 174,000 төгрөгөөр тогтоон 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Нийгмийн халамжийн тэтгэврийг 2019 онд нийт 42468 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгоход 74.2 тэрбум төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан байна.

2) Нийгмийн халамжийн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан нийгмийн халамжийн тэтгэмжийг дараахь иргэнд олгож байна.

Асаргааны тэтгэмжийг:

- Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;
- Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодын хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа хүүхдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүүхэд хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамрагдсан байгаа;
- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэнд тус тус олгодог.

2019 онд 16-аас дээш насны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа 16565 иргэнд 11.7 тэрбум төгрөгийг, 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 12581 иргэнд 10.5 тэрбум төгрөгийг тус тус халамжийн сангаас олгосон байна.

Засгийн газрын 2019 оны “тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 227 дугаар тогтоолоор байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх, эцэгт олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг 114,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг:

- Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх;
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн;
- Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;
- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай, дөрөв ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон эцэг, эх;
- Хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд;
- 16-аас дээш насны байнгын асаргаа шаардлагатай ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн

Түүнчлэн байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг сар бүр олгож байна.

Дээрх мөнгөн тусламжид 12599 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдаж 19.1 тэрбум төгрөг зарцуулсан. Мөн 16-аас дээш насны байнгын асаргаа шаардлагатай ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улиралд нэг удаа эм тариа авахад нь дэмжлэг болгон олгодог 60.000 төгрөгийн тэтгэмжийг 2019 онд 40402 иргэн /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн/ авч 8.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11-д “Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур

үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/69/48 дугаар хамтарсан тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт шалгуур, үзүүлэлт”-ийг батлан хэрэгжүүлж байна.

Өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийн дагуу ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний байнгын асаргаа шаардлагатай эсэхийг сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын дэргэдэх Эмнэлэг хяналтын комисс, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байнгын асаргаа шаардлагатай эсэхийг аймаг, дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тодорхойлж байна.

Жагсаалт, шалгуур үзүүлэлт батлагдсанаар асаргаа шаардлагатай иргэнийг шинээр тодорхойлох, хугацааг сунгах, цуцлахад эрүүл мэндийн байгууллага, эмч мэргэжилтнүүд нэгдсэн ойлголт, нэг мөр мөрдөх баримт бичигтэй болж, асаргаа шаардлагатай иргэнийг үнэн зөв, оновчтой тогтоох боломжтой болсон.

Өвчин, гэмтлийн жагсаалт:

- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох- 9 бүлэг, 82 онош
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох -12 бүлэг, 54 онош

Шалгуур үзүүлэлт /үнэлгээний хуудас/:

- Байнгын асаргаа шаардлагатай иргэн – 12 үзүүлэлт
- Оюуны хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй хүн- 14 үзүүлэлтээс тус тус бүрдэж байна.

#### Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу үйлчилгээ авч, тусламж, хөнгөлөлтийг эдлэх эрхтэй.

#### Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан дараах 9 төрлийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байна.

- 18.1.1.амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах;
- 18.1.2.зөвлөгөө өгөх;
- 18.1.3.сэргээн засах үйлчилгээнд хамруулах;
- 18.1.4.түр байрлуулан асрамжлах, хүчирхийлэлд өртсөн хүнийг түр хамгаалан байрлуулах; /Энэ заалтад 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/
- 18.1.5.өдрийн үйлчилгээнд хамруулах;
- 18.1.6.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах;
- 18.1.7.иргэн, түүний гэр бүлийн хэрэгцээнд тулгуурласан нийгмийн халамжийн бусад үйлчилгээ үзүүлэх;
- 18.1.8.гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байрлуулах;
- 18.1.9.нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

#### Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд харж хандах хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулан байршуулж, хооллон, асаргаа сувилгаа, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна.

Хөнгөлөлт, тусламж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан 17 төрлийн хөнгөлөлт, тусламжинд хамрагдаж байна. /хавсралт 1-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиас дэлгэрэнгүй харна уу/

1/ байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

2/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

3/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;

4/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

5/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

6/ насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

7/ дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

-хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;

- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

8/ бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

9/ нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

10/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

11/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

12/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

13/ хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

14/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;

15/ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах;

16/ Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулах;

17/ хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих хөнгөлөлт эдлэх.



Тулгамдаж буй асуудал

1/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт “Хөгжлийн бэрхшээлтэй хүн олимп, паралимп, дифлимп, тусгай олимп, тивийн наадам, дэлхийн зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн тохиолдолд түүний оролцсон тэмцээний давтамжийн хугацаанд ногдох тэтгэвэртэй нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно” гэснийг аль сангаас урамшуулал олгох тухай хуульд заагаагүй тул хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэх;

2/ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүй зорчино. Энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг нийслэл, орон нутгийн төсөвт жил бүр тусган, хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүний дагуу орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийслэл хотод нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих цахим картыг нэг цэгийн төвүүдээр 2017 оны 10 дугаар сараас эхлэн өнөөдрийг хүртэл олгож байна. Гэвч аймаг, орон нутгаас нийслэлд ирж нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл, зорчилтын тоонд үндэслэн санхүүжилтийг аймаг бүрээр гарган Нийслэлийн нийтийн тээврийн газраас аймгуудын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн холбогдох санхүүжилтийг ирүүлэхийг шаардаж байгаа боловч ихэнх аймгууд төсөвт тусгагдаагүй гэсэн шалтгаанаар төлбөрийг шилжүүлэхгүй байна. Иймд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийтийн тээврийн татаасыг аймаг бүр тухайн жилийн төсөвтөө тусган ИТХ-аар батлуулан хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах;

3/ Хөгжлийн бэрхшээлтэй иргэний протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг үнэ ханшийн өсөлт, инфляцын түвшинтэй уялдуулан шинэчлэх, ортопед, тусгай хэрэгсэл нийлүүлдэг байгууллагуудад тавих хяналтыг сайжруулахад ХХҮЕГ, ХБХХЕГ-тай хамтран ажиллах.

## ТАВДУГААР БҮЛЭГ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

### Холбогдох хууль тогтоомж

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар дараах хууль тогтоомжид тусгасан.

Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах;

- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулинд монгол иргэдийг авч ажиллуулж буй гадаад орны аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн нөхцөлд Монгол Улсын иргэн гадаад улсад хөдөлмөр эрхэлж байхдаа хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрэн алдсан тохиолдолд ажил олгогчоос ажилтанд олгох төлбөр, тэтгэмж, нөхөн төлбөрийн хэмжээг тусгах заалтыг шинээр нэмж оруулсан нь гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжийг дээшлүүлэх;

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийг орлогыг албан татвараас чөлөөлөх, 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүний ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй хүний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан 10 сая хүртэлх хэмжээний төгрөгийн хандивыг тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцож байх;

- Хөдөлмөрийн тухай хуулийн 111.6-д "Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө" гэж тус тус тусгасан байдаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 128 дугаар зарлигийг хэрэгжүүлж төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 111 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

Хүснэгт 7. Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо (бүсээр)	Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцох
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр
2	Бусад аймаг	Тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байсан бөгөөд хуулийн хэд хэдэн бүлгийн зохицуулалтад өөрчлөлт оруулахад бүтэц, уялдаа нь алдагдахад хүрэх

тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах талаар тусгасан.

Хуулийн төслийн зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, түүний төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоотой холбогдсон харилцааг боловсронгуй болгоход оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг тодорхойлох дэд ажлын хэсгийг 2018 оны А/140 дугаар тушаалаар байгуулсан.

Хуулийн үзэл баримтлалыг батлуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар тусгайлан нэг бүлэг оруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/140 дугаар тушаалаар дэд ажлын хэсгийг байгуулаад байна.

### **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр**

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтлах зорилтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх - Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох болон нийгэмшүүлэх, ажлын байр, үйлдвэрлэлийн орчинтой танилцуулах, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн дэг журам, аюулгүй ажиллагааны анхан шатны мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах багц үйлчилгээг үзүүлнэ.

- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах - Шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтийг харгалзан хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамруулах, ажлын ярилцлагад ороход туслах, ажлын байр, ажил олгогчтой танилцуулах зорилгоор хөтөч, дохионы хэлмэрч ажиллуулна.

- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ - 5.0 хүртэл сая төгрөгийн дэмжлэгийг 4 хүртэл жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэйгээр олгоно.

- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ - Бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүсэлтэд үндэслэн боловсруулсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх болон ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд хамруулна.

- Аж ахуй эрхлэлтийн сургалт - Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан болон бичил бизнес эрхэлдэг, цаашид эрхлэх хүсэл сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэн, байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг хүсэлтийн дагуу хамруулна.

- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт - Эрх бүхий мэргэшсэн, боломжит тохируулгатай сургалтын орчин бүрдсэн мэргэжлийн байгууллагаар тусгайлсан сургалтын хөтөлбөрт суурилсан хэлбэрээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1-10 сарын хугацаанд багтаан мэргэжлийн ур чадвар, чадамж олгоно.

- Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тогтвортой буюу 12 сараас дээш хугацаагаар байнгын ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх урамшууллыг олгоно.

"Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийг 2019 онд хэрэгжүүлэхэд 12 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 5622 иргэн хамрагдаж 3,542,869.6 мянган төгрөг зарцуулж 1161 ажлын байр бий болсон байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд 733 иргэнийг хамруулж 45.1 сая төгрөг;

- Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах арга хэмжээнд 130 иргэнийг хамруулж 16.6 сая төгрөг;

- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 643 иргэнийг хамруулж 2,057.9 сая төгрөг;

- Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 910 иргэнийг хамруулж 160,4 сая төгрөг;

- Аж ахуйн эрхлэлтийн ур чадвар олгох сургалтад 2254 иргэнийг хамруулж 66.6 сая төгрөг;

- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 726 иргэнийг хамруулж 148.6 сая төгрөг;

- Ажил олгогчийн дэмжлэгт 336 иргэнийг тогтвортой ажлын байраар хангасан 226 ажил олгогчид 1,047,307 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Эдгээр арга хэмжээнээс Ажил олгогчид олгох санхүүгийн дэмжлэгийн үйл ажиллагааг Хөдөлмөр,

халамжийн үйлчилгээний ерөнхий газар 2018 оноос хариуцан зохион байгуулдаг болсон.

Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор төрийн бус болон аж ахуйн нэгж байгууллагуудын төслийг хүлээн авч сонгон шалгаруулалтыг зохион байгуулж байна.

Нийт 69 байгууллагын төсөлд санхүүгийн дэмжлэг олгох гэрээ байгуулан хяналт тавьж ажиллаж байна.

Хүснэгт 8. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хамрагдалт, аймаг, нийслэл, дүүргээр, зарцуулсан хөрөнгө

Д/Д	Аймаг, дүүргүүд	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүний тоо	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Нийт хамрагдсан хүний тоо	Нийт зарцуулсан хөрөнгө /мян.
1	Архангай	21		12	75	20	8	0	136	67,080.00
2	Баян-Өлгий	24		23	22		35	3	107	83,949.20
3	Баянхонгор	19		29	66	13	46	3	176	71,690.00
4	Булган	12	2	15	42	12	2	4	89	56,937.00
5	Говь-Алтай	15		16	54	22	270	1	378	50,990.00
6	Дорноговь			8	34	11	1	0	54	43,659.00
7	Дорнод	21		17	72	15	9	4	138	78,326.00
8	Дундговь	15		6	51	10	8	0	90	47,207.80
9	Завхан	23		14	75	16	0	0	128	61,772.00
10	Өвөрхангай	26	6	30	105	19	3	0	189	75,907.00
11	Өмнөговь	15		12	53		22	1	103	46,460.00
12	Сүхбаатар	16		11	21	11	1	0	60	50,259.80
13	Сэлэнгэ	26		13	90	18	0	2	149	65,142.00
14	Төв	2		18	42		0	2	64	62,504.50
15	Увс			32	74	19	30	0	155	61,966.00
16	Ховд	80	4	28	78	34	25	2	251	86,668.00
17	Хөвсгөл	27	15	20	97	26	85	1	271	96,093.00
18	Хэнтий			13	19	7	7	0	27	66,026.00
19	Дархан-Уул	22		19	78	22	34	3	178	75,720.00
20	Орхон			9		16	0	3	28	57,090.00
21	Говьсүмбэр	8		8	14	8	0	1	39	31,556.00
22	Багануур	15		14	56		1	0	86	48,090.00
23	Багахангай	6		6	4		5	0	21	30,910.40
24	Баянгол	54	11	40	181	44	9	4	343	183,382.00
25	Баянзүрх	64	12	39	235		11	2	363	219,890.00
26	Сонгинохайрхан	70	12	82	239		266	0	669	229,900.00
27	Сүхбаатар	44		24	104		6	2	180	134,038.00
28	Хан-Уул	45		33	70		13	1	162	146,090.00
29	Чингэлтэй	42	68	35	156		7	3	311	152,916.50
30	Налайх	21		17	47		6	2	93	71,310.00
31	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар					383	0	0	383	88,339.40
32	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар						182	182		901,000.00
	Бүгд	733	130	643	2254	726	910	226	5603	3,542,869.60

## Мэргэжлийн боловсрол, сургалт

Монгол Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 80 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгаагаас 79 нь үйл ажиллагаа явуулж байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын 50 байгууллага нь төрийн өмчийн, 29 байгууллага нь төрийн өмчийн бус байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад 2019-2020 оны хичээлийн жилийн эхэнд нийт суралцагчид 37806 байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 551, үүнээс 251 нь эмэгтэй суралцагч байна.

Хүснэгт 9. 2019-2020 оны хичээлийн жилд МБСБ-д суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл

Д/д	Бэрхшээлийн хэлбэр	Нийт	Эмэгтэй
1.	Хараа	144	56
2.	Сонсгол	56	24
3.	Яриа	58	22
4.	Хөдөлгөөн	127	63
5.	Сэтгэц	56	23
6.	Бусад	110	63
	Нийт	551	251

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг тусгасан байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын бүтэц, бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд хамаарах ба хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авьяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэх зорилготой.

Энэхүү хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийг хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Хөтөлбөрийн 4.4.4 дүгээр заалтад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх” талаар мөн тусгасан байна.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгож, тэдэнд харилцаа, амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, бейн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг онол, дадлага хослуулан заадаг.

2018-2019 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 47,1% нь ажлын байранд зуучлагдсан байна.

Харилцаа холбоо, хүнсний үйлдвэрлэл, иргэний барилга байгууламж, үйлчилгээ, гар урлаач, дизайнч, хөнгөн үйлдвэрлэл гэсэн мэргэжлийн чиглэлүүдээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжил олгодог улсын ууган бөгөөд цорын ганц төрийн өмчийн сургууль юм.

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн даргын 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/28 дугаар тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх элсэлтийн хяналтын тоог тогтоон 8 мэргэжлээр 15-45 насны зорилтот бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг элсүүлэн сургаж байна.

Тус сургууль хөгжлийн бэрхшээлтэй 135 суралцагч байгаагаас 17 нь сонсголын бэрхшээлтэй байна.

Сонсголын бэрхшээлтэй суралцагчдын дийлэнх нь хэл ярианы хавсарсан эмгэгтэй байна. Харааны бэрхшээлтэй 2 суралцагч, хэл ярианы бэрхшээлтэй 2 суралцагч, тулгуур эрхтний бэрхшээлтэй 33 суралцагч, сэтгэцийн бэрхшээлтэй 12, бусад хавсарсан бэрхшээлтэй 52 суралцагч суралцаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй дээрх суралцагчид нь манай сургуульд 8 мэргэжлээр суралцаж байна. Суралцагчдын 65 нь эмэгтэй байна.

2019-2020 оны хичээлийн жилд 134 суралцагч элссэнээс 65 нь эмэгтэй суралцагч байна.

2019-2020 оны хичээлийн жилд 134 суралцагч суралцаж байгаагаас 103 суралцагч нь Улаанбаатар хотынх бөгөөд 31 суралцагч хөдөө орон нутгаас ирж суралцаж байна.

Хүснэгт 10. МБУЧОС-д 2014-2019 онд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл

№	Хичээлийн жил	Суралцагчдын тоо
1	2014 - 2015	85
2	2015 - 2016	65
3	2016 - 2017	69
4	2017 - 2018	116
5	2018 - 2019	139
6	2019 - 2020	134
Нийт		608

Хүснэгт 11. 2019-2020 оны хичээлийн жилд суралцагчдын мэдээлэл

№	Мэргэжлийн чиглэл	Суралцагчдын тоо
<b>1 жилийн анги</b>		
1	Гар утас, телефон аппаратны засварчин	9
2	Бэлэг дурсгалын зүйл урлаач	16
3	Модон эдлэлийн мужаан	7
4	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	9
5	Тогооч	12
<b>2.5 жилийн анги</b>		
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин	24
2	Сийлбэрчин	10
3	Хэвлэлийн график дизайны анги	41
4	Сүлжмэлийн үйлдвэрлэлийн технологийн ажилтан	6
<b>Суралцагчдын нийт тоо</b>		134

## Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв

Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо нь хараагүй иргэдийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин соёл урлаг, спорт, эрүүл мэндийн чиглэлээр төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж, гишүүдийнхээ эрхийг хамгаалах, нийгмийн харилцаанд оролцоход нь бүх талын дэмжлэг үзүүлэх зорилготой, гишүүддээ үйлчилдэг, ашгийн бус, төрийн бус байгууллага юм. Тус холбоо анх 1978 онд Монголын хараагүй, дүлий иргэдийн нийгэмлэг нэртэйгээр байгуулагдсан. 1993 онд Монголын хараагүйчүүдийн нийгэмлэг, 2005 онд Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбоо болон зохион байгуулагдаж, 21 аймаг, нийслэлийн алслагдсан 2 дүүрэг нийт 23 салбараар дамжуулан үндэсний хэмжээнд нийт 9600 орчим бүрэн хараагүй болон сул хараатай гишүүдийнхээ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ахмад, эмэгтэйчүүд, залуучууд, спорт, соёл, урлагийн зөвлөлүүд холбооны бүтцэд ажиллаж байна.

Тус холбооны дэргэд Ярьдаг болон брайль ном хэвлэх төв, "BEST FM 98.5" радио станц, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Нөхөн сэргээх сургалтын төв, Хөдөлмөрийн бирж, "Best massage" сүлжээ төв, "Нарны хаан хүүхдүүд" тусгай цэцэрлэг, "Сафй more" кофе шоп тус тус үйл ажиллагаа явуулдаг. Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо /МХҮХ/ нь 2005 оноос эхлэн хараагүйчүүдийн Нөхөн сэргээх сургалтын төвийг байгуулан ажиллаж байгаад 2015 оны 8-р сараас эхлэн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв /МСҮТ/ болгон өргөжиж 4 дэх хичээлийн жилдээ амжилттай үйл ажиллагаагаа явуулж байгаа билээ. МХҮХ-ны дэргэдэх МСҮТ нь Монгол Улсын хэмжээнд харааны улмаас хөдөлмөрийн чадвараа 50 буюу түүнээс дээш хувиар алдсан насанд хүрсэн харааны бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлж, авьяас чадварыг нь хөгжүүлж, тэдний онцлог, ур чадварт тохирсон мэргэжлийн боловсрол олгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх зорилготой.

Тус сургууль нь Эмчилгээний бариа засалч, Алжаал тайлах бариа засалч, Бэлэг дурсгалын зүйл урлаач, Компьютерын оператор, Ардын гоцлол хөгжимчин гэсэн 5 мэргэжлээр элсэлт авч байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд шинээр Даралтат хөгжимчин, Кофе бэлтгэгч гэсэн хоёр шинэ мэргэжлийн элсэлт нэмж үйл ажиллагаагаа улам өргөжүүлж ажиллаж байгаа юм. Мөн Компьютерийн операторч мэргэжлийн нэршлийг Хүртээмжит технологийн мэргэжилтэн болгон өөрчилж олон улсын харааны бэрхшээлтэй иргэдийн техник технологийн тусгай тоног төхөөрөмжтэй ажиллах, программ хөгжүүлэх ур чадварыг олгож байна. Мөн орон зайн чиг баримжаа олгох болон брайль бичгийн сургалтуудыг тодорхой хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаг. Тус төв нь 36 хүн хүлээн авах хүчин чадал бүхий дотуур байртай бөгөөд хөдөө орон нутгийн суралцагчдыг дотуур байранд байрлуулж сурах нөхцөл боломжоор бүрэн хангаж байна.



Орон зайн чиг баримжаа олгох сургалт



Массажны өрөө

МХҮХ-ны дэргэдэх МСҮТ –ийн эмчилгээний бариа засалч, алжаал тайлах бариа засалч мэргэжлээр төгссөн төгсөгчид МХҮХ-ны дэргэдэх болон бусад "BEST MASSAGE" сүлжээ төвд ажиллаж 99% ажлын байраар хангагддаг бөгөөд "Кофе бэлтгэгч, Бариста" мэргэжлээр төсөгчдийг ажлын байраар хангах зорилгоор "CAFE MORE" Кофе шопын салбарыг 2018 оны 7 дугаар сард Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны байранд, 11 дүгээр сард Засгийн газрын 11 дүгээр байранд "CAFE MORE" Кофе шопын хоёр дахь салбарыг байгуулж тохь тухтай цэвэр цэмцгэр орчинд, мэргэжлийн өндөр түвшинд нийтэд үйлчлэн ажиллаж байна.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНД

### 1. Холбогдох хууль тогтоомж

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан.

Бодлогын баримт бичгийн гол зорилго нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, үйлчлүүлэгчээ дагасан зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгахад орших юм.

#### Эрүүл мэндийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлох, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцох, бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн тусламж авах нөхцөлийг хангахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### "Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах" үндэсний хөтөлбөр (2014-2021)

I үе шат: 2014-2017 он

II үе шат: 2017-2021 он

Хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчний хяналт, тандалт, менежментийг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчний өвчлөл, чадвар алдалт, цаг бусын эндэгдлийг бууруулах орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

### 2. Үйл ажиллагааны хэрэгжилт

Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Тус хуулийн төслийн үзэл баримтлалд Эмнэлгээс гарсны дараа архаг өвчний эмнэлзүйн эзэнэгшлээ алдсан үед урт хугацаанд үзүүлэх "Эрүүл мэндийн урт хугацааны тусламж, үйлчилгээ"-г тодорхойлсон заалт нэмж, архаг суурь өвчтэй хөгжлийн бэрхшээлтэй, эмнэлгээс гарсны дараа урт хугацаанд сэргээн засах, сувилахуйн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэнд эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээг хослуулан үзүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын сэргээн засах тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг 2019 оны 07-08 дугаар сард салбар дундын техникийн ажлын хэсэг, Монгол Улс дахь ДЭМБ-ын Суурин төлөөлөөгчийн газар, Бүсийн олон улсын зөвлөх хамтран Улаанбаатар хот, Орхон, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын сэргээн засахын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагууд дээр газар дээр нь очиж хийсэн. Цаашид үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн сэргээн засах тусламж, үйлчилгээний 2020-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/196 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Сэргээн засах төв, сувилалд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, журам болон сувилал,



сэргээн засах төвд илгээх үйлчлүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/502 дугаар тушаалаар батлуулаад байна.

MNS 6801:2019 Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/60 дугаар тушаалаар батлагдсан. MNS 5232:2019 Сувиллын бүтэц, үйл ажиллагааны стандарт Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/60 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

Эрүүл мэндийн сайдын “Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орыг төлөвлөх аргачлал батлах тухай” 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/266 дугаар тушаалаар сэргээн засахын орыг шинээр төлөвлөсөн нь урт хугацааны тусламж, үйлчилгээнд томоохон хувь нэмэр оруулсан.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар Сэргээн засах төвийн барилга, 36 ортой / Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт 4 тэрбум төгрөг, 2019 онд санхүүжих дүн 500 сая төгрөгөөр батлагдсан. Барилгын ажлыг гүйцэтгэгч, Эрүүл мэндийн яамтай 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд барилга угсралтын ажлын явц 30 хувьтай байна. Гэрээний дагуу 2020 онд ашиглалтад хүлээлгэн өгөх бөгөөд улсын төсөвт 2.0 тэрбум төгрөг тусгагдсан.

Сэргээн засах тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 1 иргэнд 110.000 төгрөгний хөнгөлөлт үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас 2019 оны эхний 11 сарын байдлаар орон нутаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 53 эрүүл мэндийн байгууллагад сэргээн засах тусламж, үйлчилгээнд нийт 8.4 тэрбум төгрөг зарцуулаад байна.

Сэргээн засахын болон сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээний өртөг, зардлын судалгааг хийж, 2020 оны 01 дүгээр 01-ний өдрөөс уг тусламж, үйлчилгээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын төлбөрийн хэмжээг 250,0 мянган төгрөг болгож, 127,3 хувиар буюу 2,3 дахин өсгөн санхүүжүүлэхээр болсон.

2019 оны 05 дугаар сард “Нярайн скринингийн үндэсний анхдугаар конгресс”-ийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын удирдлага, нярай, дүрс оношилгоо, сонсгол, нүдний эмч, мэргэжилтнүүд, мөн эцэг эхийн төлөөлөл, Монгол Улс дахь Олон улсын байгууллагууд, хамтын ажиллагаатай улс орны зочид зэрэг нийт 400 гаруй төлөөлөгчид оролцсон.

#### 1. “Нярайн тандалт шинжилгээний хөтөлбөр”-ийн талаар

- Нярайн сонсголын скрининг: Нийт нярайн сонсголын тандалтанд 2019 онд улсын хэмжээнд нийт 28577 нярайг хамруулснаас ЭХЭМҮТ-ийн төрөх тасагт 8583 нярай, бусад амаржих газар 19,994 хийсэн байна. Шинжилгээнээс харахад 90 нярайд сонсгол бууралт оношилогдсон.

- Оношилгоонд хөнгөн хэлбэртэй, дамжуулах хэлбэр хавсарсан-19 тохиолдолд эмийн эмчилгээ хийгдсэн. Дунд-30, хүндэвтэр-17 хүнд-17 хүүхдэд дүлий-7, микрооти-10 тохиолдлыг оношлогдсон. Сонсгол судлалын кабинетын хяналтад авсан.

- 2019 онд нийт 5 хүүхдэд дунгийн суулгац мэс засал хийгдсэн. 2015 оноос хойш ЭХЭМҮТ-д 16 хүүхдэд дунгийн суулгац мэс заслыг хийгээд байна. 7 хүүхдэд сонсгол нөхөн сэргээх, агааржуулах гуурс тавих эмчилгээг хийсэн.

- Дутуу нярайн ретинопатийн илрүүлэг: Дутуу нярайн ретинопатийн оношилгоог 2019 онд нийт 1543 дутуу нярайд ДНР-ийн үзлэг хийгдэж, 343 хүүхдэд эмгэг илэрсэн. Үүнд:

- ДНР-ийн 1-р хэлбэр оношлогдсон 43 хүүхдэд эмгэг судасны ургалтыг зогсоох (тариа-35, лазер-8) эмчилгээ хийж, идэвхитэй хяналтад авсан бөгөөд 11 хүүхэд эдгэрсэн байна.

- ДНР-ийн 2-р хэлбэр оношлогдсон 300 хүүхдүүд эмийн эмчилгээгүй намжмал байдалд орсон.

- Түнхний үений дутуу хөгжил, мултралаас сэргийлэх: Швейцар-Монголын эмч нарын хамтарсан баг Нярайн түнхний үений дутуу хөгжил, мултралыг дэлхийн жишигт хүрсэн аргаар 2007 оноос хойш оношилж эхэлсэн.

- ЭХЭМҮТ-д онош баталгаажуулах хэт авиан үзлэгт хамрагдсан 17449, үүнээс 1088 хяналтанд авч, 605 нярайг эмчилгээний дараах аргуудаар эмчилсэн.

- Өлгийдөлтийн аргаар 190, дөрөөвч зүүлгэж 345, татлагааар 9, мэс заслын аргаар 5, 246 хүүхдийг үргэлжлүүлэн хянаж байна.

- Бодисын солилцооны эмгэгийн оношилгоо: 2019 онд шээсэнд органик хүчил тодорхойлох шинжилгээг нийт 35 хүүхдэд хийж гүйцэтгэсэн. Одоогоор онош батлагдсан тохиолдол үгүй.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын ВИЖН 2020 стратегийн хүрээнд ДЭМБ, ЭМЯ, Нүдний эмч нарын нийгэмлэг, Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо хамтран сул хараатай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах, чанартай мэргэжлийн түвшинд ард иргэдэд тусламж үзүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллага болох Америкийн нэгдсэн улсын хараагүйчүүдийн Перкинсийн их сургуультай хамтын ажиллагааг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 2019 оны 01 дүгээр сард АНУ-ын хараагүйчүүдийн Перкинсийн их сургуулиас Монгол Улсад 2 мэргэжилтэн ирж сул хараатай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулахад шаардлагатай стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.

3. Эрүүл мэндийн сайдын “Заавар батлах тухай” 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/517 дугаар тушаалаар “Настны сэтгэл гутрах эмгэгийн эмнэлзүйн заавар”, “Насны доройтлын үнэлгээний заавар”, “Настны шээс алдрах эмгэгийн эмнэлзүйн заавар”, “Настны баас хатах шинжийн эмнэлзүйн заавар”, “Олон мэргэжлийн багийн тусламж үзүүлэх заавар” тус тус батлагдсан.

## ДОЛООДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ

### 1. Холбогдох хууль тогтоомж

Монгол Улсын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлд “төрөөс бүх нийтийн боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуул болно” гэж сурч, боловсрох эрх талаар тусгасан.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/-д “боловсролын байгууллагын үйл ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтаас ангид, иргэдийн эрх ашиг, эрүүл мэнд, ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдалд харшлахгүй байх” гэсэн зарчмыг баримтлана.

Боловсролын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тусгай хэрэгцээтэй уялдуулан тогтоох, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багш ажилтан нь тусгай хэрэгцээнд нийцсэн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан, бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгасан.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар бүлгийн “Цэцэрлэг, түүний зохион байгуулалт”-д хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон заах арга барил эзэмшсэн, тухайн хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, сэргээн засалч, нийгмийн ажилтанг ажиллуулах мөн цэцэрлэгийн багшид олгох нэмэгдлийн талаар тусгаж өгсөн. Түүнчлэн хөнгөн хэлбэрийн бэрхшээлтэй 2 хүртэл хүүхэд ердийн нэг бүлэгт байж болох зохицуулалтыг тусгасан.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд Ерөнхий боловсролын тусгай сургуулийн талаар тусгаж өгсөн. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх үйлчилгээ үзүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллах бөгөөд суралцагчийн онцлогт тохирсон заах арга эзэмшсэн байх зэрэг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх, орчин нөхцөл, багшийн мэргэжлийн талаар тусгаж өгсөн. Мөн хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх зэрэг нийгмийн харилцанд тэгш оролцох зохицуулалтыг оруулж өгсөн.

Хүснэгт 12. Боловсролын салбарт 2019 онд шинээр батлагдсан эрх зүйн баримт бичгүүд

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Дугаар
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаал</b>			
1	"Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм"	2019.03.06	А/118
2	"Хүүхдийн цэцэрлэгийн сэргээн засалч багшийн албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт"	2019.07.05	А/430
3	"Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр"-ийг баталсан. Хоёр. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй"-н хэсэгт Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?, Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ?	2019.08.02	А/494
4	"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"	2019.05.14	А/292
5	"Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл "	2019.03.07	А/119
6	"Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл"	2019.03.07	А/119
7	"Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар	2019.08.15	А/508
8	"Чиглэл батлах тухай"	2019.08.27	А/528
9	"Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам"-ыг баталсан	2019.12.17	А/803
10	"Насан туршийн боловсрол" хөтөлбөр	2019.11.28	А/756
<b>Батлагдсан стандарт</b>			
1	"Монгол брайль бичгийн стандарт" MNS6800:2019	2019	2019 оны СХЗГ-ын даргын С/58 тоот тушаалаар
2	"Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын Ерөнхий шаардлага" MNS6782:2019	2019	2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоот
3	"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага" MNS6799:2019	2019	2019 оны СХЗГ-ын даргын С/40 тоот

Эдгээр эрх зүйн баримт бичгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих, сурч боловсрохтой холбоотой зохицуулалтууд орсон.

## 2. Үйл ажиллагааны хэрэгжилт


### *Хамран сургалт*

Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1,076 хүүхэд цэцэрлэгт, 6,301 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд тус тус суралцаж байна.

Хүснэгт 13. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт

№	Насны ангилал	Бүх хүүхдийн тоо	Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	Хувь
1	2-5 настай	1,585	1,076	67,8
2	6-18 нас	8,209	6,301	76,7
3	Бүгд	9,794	7,377	75,3

Зураг 6. Цэцэрлэг, сургуульд суралцаж буй хөгжлийн хүүхдийн тоо



*Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл явцыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ:*

БСШУС-ын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хэв шинжтэй ерөнхий боловсролын сургуульд суралцахад сургалтыг хэрхэн зохион байгуулах, дэмжлэгийг хэрхэн үзүүлэх талаар зохицуулсан чухал баримт бичиг юм. Дээрх журмын хэрэгжилтийг ханган 21 аймаг, 9 дүүрэгт «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл»-ийг аймаг, дүүргийн БСУГ-ын тушаалаар байгуулсан. Мөн журмын дагуу бүх сургуульд «Дэмжих баг» байгуулагдан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ны А/155-р тушаалаар баталсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал, зөвлөмж”-ийн дагуу тухайн сургууль сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрт зориулсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах, хүүхдийн сурах орчин, тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байна.

БСШУС-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/625 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” тушаалаар Боловсролын хүрээлэнд шинээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор”-ийг байгуулсан. Тус сектор нь эрдэм шинжилгээ, судалгаа хийх, ХБХ-ийг хөгжүүлэх арга зүй боловсруулахаас гадна “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг хариуцан ажиллах юм. Төв нь нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг, эх, багш нарт дэмжлэг үзүүлнэ.

2019 оны 12 дугаар 03-ны өдрийн «Монгол брайль үсгийн стандарт»-ыг батлууллаа. “Монгол брайль бичгийн стандарт” батлагдсанаар хараагүй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэдтэй брайль үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэж, харилцааны чухал хэрэглүүр болсон юм. Цаашид багш нарт брайль үсгийн анхан шатны мэдлэг олгох, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бичиг үсэг тайлагдаагүй харааны бэрхшээлтэй хүнд бичиг үсэг заах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх юм.

## Ном сурах бичиг

2019 онд “Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшинг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн” 2019 он, “Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн” 2019 он, “Дохионы хэлээр харилцаж сурцгаая” Сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан багц карт 2019 он, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үгийн нөөц нэмэгдүүлэх хэл ярианы дутмагшилтай хүүхдэд зориулсан “Зурган таних тэмдгийн эмхэтгэл”-ийг 144.886.000 төгрөгөөр 29.700 ширхэг хэвлэн улс бүх сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлэн судлуулж байна.

Мөн шинээр “Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээлийн багшийн ном, “Яриа бичиг” хичээлийн багшийн ном, “Биет зүйл” хичээлийн багшийн номыг боловсруулан гаргасан. Оюуны бэрхшээлтэй сурагчдад зориулсан 1-4-р ангид судлах Математикийн, 2, 4, 5-р ангийн Монгол хэлний хичээлийн сурах бичгийг, 1-4-р ангид хичээл заах багшид зориулсан Хэл засал, Нийгэм ахуйн баримжаа номыг хэвлэн ашиглаж байна.

Сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Японы Хүүхдийг ивээх сангийн “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд “Сургуулийн гадна буй сургуулийн насны хүүхдийг илрүүлэх судалгаа”-г төсөл хэрэгжиж буй 2 аймаг /Ховд, Өвөрхангай /, 3 дүүрэг /Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан/-ийн 18 баг, 20 хороонд хийв. Судалгааны үр дүнд сургуулийн гадна буй сургуулийн насны нийт 340 хүүхэд илрүүлснээс 121 нь сургууль завсардсан, 219 нь сургуульд огт ороогүй байна. Эдгээр хүүхдүүдийн 217 нь хөгжлийн бэрхшээлтэй байсан бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд аймаг, дүүргийн Насан туршийн боловсролын төвийн бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 21.5%-ийг нь хамруулаад байна.

Тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтанд зориулсан үндсэн сургалтад нийт 1,316 багш, арга зүйч, эрхлэгч хамрагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрт “Хэлний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” арга зүй сэдвийг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна. 17 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургуулийн өмнөх боловсролын сургууль зэрэг 8 байгууллагатай хамтран «Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт /нийгмийн загвар/», «Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барил», «Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлд нь хөгжлийг дэмжих Портеж хөгжлийн зориулалт, ажиллах арга зүй” сэдвээр 1,584 багш, туслах багш, эцэг эхэд зориулсан сургалтыг зохион байгуулсан.

2019-2020 оны хичээлийн жилд Тэгш хамруулан сургах боловсрол онлайн курст 2137 багш, сургалтын байгууллагын удирдах ажилтан хамруулан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүллээ. Мэргэжил дээшлүүлэх танхимын сургалтаар 10 дахь жилдээ ажиллаж буй нийт 14 мэргэжлийн 1200, 5 дахь жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 722, эхний жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 1360, нийт 3291 багш ажилтнуудад тэгш хамруулан сургах боловсролын агуулга сэдвээр 112 цагийн хичээл бэлтгэн зааж, мэдлэг ойлголт, арга зүйн хөгжлийг дэмжлээ. Орон нутаг, нийслэлийн “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй ажиллаж буй 20 багшийг үндсэн сургалтад хамруулж мэргэжлийг нь дээшлүүллээ. “Тусгай хэрэгцээт боловсрол-Багшлах арга зүй” 24 цагийн сонголтот сургалтад сургууль, хүүхэд хөгжлийн төв, төрийн бус байгууллагын 23 багшийг хамруулж батламж олголоо. Хэнтий аймгийн Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуулийн 98 багш ажилтанд 2 үе шаттайгаар “Тэгш хамруулан сургах боловсролд хүүхэд бүрийг хамруулах боломж” захиалгат сургалтыг зохион байгууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Сэтгэцийн эрүүл мэнд”, “ICF”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах арга зүйд сургах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, засан сайжруулах, ахуйн баримжаа олгох” зэрэг цуврал сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 200 орчим багш, эцэг эх хамрагдлаа.

Ерөнхий боловсролын 55 дугаар тусгай сургуулийн 3 багшийг Унгар улсад, 29 дүгээр сургуулийн 3 багшийг ОХУ-ын Санкт-Петербург хотод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгууллаа. 2019 оны 12 дугаар сард нийслэлийн 6 дүүргийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нийт 500 хүнийг “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд сургах нь” сургалтад хамруулсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр насан туршийн боловсролын багш нарын тэгш хамруулах болон тусгай боловсролын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг тусгай хэрэгцээт хүүхдүүдтэй холимог бүлэгт зохион байгуулах арга зүйг сайжруулах, НТБ-ын төвүүдийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор “Тэгш хамруулан сургах боловсрол” холимог бүлгийн багш нарыг чадавхжуулах сургалтыг үндэсний хэмжээнд 8 бүс /Өвөрхангай, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Сэлэнгэ/-д 2019 оны 09 дүгээр сард зохион байгуулж, нийт 453 багшийг хамрууллаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр удирдах ажилтнуудын тэгш хамран сургалт, тэгш боломж, насан туршдаа суралцахуйн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хамтран ажиллах оролцоох сайжруулах зорилгоор “Тэгш хамруулан сургах боловсрол-Насан туршдаа суралцахуй” нөлөөллийн уулзалтыг 09-11 дүгээр саруудад Өвөрхангай, Дундговь, Төв, Ховд, Хөвсгөл, Завхан, Хэнтий, Сэлэнгэ зэрэг 8 аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга нар, боловсрол хариуцсан мэргэжилтэн, Засаг даргын Тамгын газрын харьяа агентлагуудын дарга, мэргэжилтэн, аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, багийн дарга нар нийт 181 хүнд зохион байгуулав. Орон нутгийн удирдлагууд насан туршийн боловсролын бодлого чиглэл, тэгш хамруулан сургах боловсролын талаарх ойлголтыг олгох, цаашид хамтран ажиллах боломж нөхцөл бүрдсэн үр дүнтэй уулзалт болсон.

Тусгай хэрэгцээт боловсролын багшийг 2015 оноос эхлэн бакалаврын сургалтаар бэлтгэж эхэлсэн бөгөөд 2019 онд анхны 9 оюутан төгссөн. Үүний 66,6% нь ажлын байраар хангагдан ажиллаж байгаагийн 2 оюутан дараа шатны магистрын сургалтад сурч байна.

#### Шигтгээ 1

#### **Монгол Улсын Боловсролын их сургуулийн Тусгай хэрэгцээт боловсролын тэнхим хэл засалч багшийг курсээр бэлтгэх захиалгат сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.**

-МУБИС-ийн багш мэргэжлийн сонгон судлах хичээлийн хөтөлбөрт 2015 оноос “Тусгай хэрэгцээт боловсрол” 2кр хичээлийг тусгаж өгсөн ба 2019 онд 636 оюутан сонгон судалсан байна.

-Тусгай хэрэгцээт боловсролын багшийн ангийн оюутнууд Дохионы хэлмэрч орчуулагчийн анхан шатны мэдлэг чадвартай болох үүднээс “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсрол”, “Дохионы хэл” хичээлүүдийг нийт 5 кр сургалтын хүрээнд судалж энэ үйл ажиллагаанд ТББ-ууд, сонсголгүй иргэдтэй хамтарч ажиллаж байна.

-2019-2020 оны хичээлийн жилээс оюутнуудыг чадавхжуулах зорилгоор дохионы хэлний анхан шатны сургалтыг Азийн Хөгжлийн Банкны дээд боловсролын төслийн хүрээнд зохион байгуулсан.

-БСШУСЯ-ны Оюутны санаачилгын тэтгэлэгт төсөлд “МУБИС-ийн оюутнуудад дохионы хэл эзэмшүүлэх”, “Харааны бэрхшээлтэй оюутны сургалтын орчин сайжруулах” гэсэн 2 төсөл шалгаран хэрэгжиж байна.

-2019-2020 оны хичээлийн жилд ОХУ-ын Москва, Санкт-Петербург, Томск хотуудад хэл засалч, согогзүйч мэргэжлээр 8 оюутан сурч байна.

#### Сургалтын орчинг сайжруулан дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

“Нийслэлийн боловсрол-2020” дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 онд багтаан 22 сургуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд боловсролд тэгш хамрагдах орчин бүрдүүлэх” зорилт дэвшүүлсэн<sup>3</sup>. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 26, 34 дүгээр сургууль, Баянгол дүүргийн 28, 113 дугаар сургууль, Сүхбаатар дүүргийн 16, 35 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн 79, 111 дүгээр сургуулиудад тэгш хамруулах орчин бүрдсэн сургуулийн жагсаалтад орсон байна.

3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайлан”



2017 онд нийслэлийн төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар дүүргийн 16, Баянзүрх дүүргийн Шавь цогцолбор сургууль, Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургуулиудад, 2018 онд 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 17, Хан-Уул дүүргийн 60, Баянгол дүүргийн 40 дүгээр сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын орчин бүрдүүлэх ажил хийгдэж бүрэн дууссан. 2019 онд Чингэлтэй дүүргийн 24, 57, Баянзүрх дүүргийн 84, Хан-Уул дүүргийн 52 дугаар сургуулиудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд суралцах сургалтын орчин бүрдүүлэх ажил хийгдэж байна. Эдгээр 10 сургууль нь дэд хөтөлбөрийн хүрээнд орчин бүрдүүлсэн сургуулийн жагсаалтад орсон байна.

2019 онд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй оны шилдэг боловсролын байгууллага"-аар Хөвсгөл аймгийн Ирээдүй цогцолбор сургууль шалгарсан. Тус сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чанартай боловсрол олгох зорилт тавин ажиллаж хөгжлийн бэрхшээлтэй 38 хүүхдийг үе тэнгийн найз нартай нь суралцуулах нөхцөлийг бүрдүүлэн, бусад сургуулиудад зөвлөн туслах ажлыг гүйцэтгэжээ. Нийслэлийн 10, 186 дугаар тусгай цэцэрлэгүүдэд 100.0 сая төгрөгийн хөрөнгөөр тоног төхөөрөмжийг сайжруулж, цэцэрлэг тус бүрт 128.0 сая төгрөгийн автобус олгосон. Сүхбаатар дүүргийн 186 дугаар тусгай цэцэрлэгт НҮБ-ын Хүүхдийн Сангийн "Дотор агаарын чанарыг дээшлүүлэх" төслийн хүрээнд 238 сая төгрөгний өртөг бүхий агааржуулалтын системийг шинэчлэх ажил хийгдэж байна.

Мөн MCS групп Total distribution компани нийгмийн хариуцлагын хүрээнд В1, 1 дүгээр давхарт Харааны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 195 ш буюу 55,6 метр дотор зам тавих ажлыг хийж гүйцэтгэв. Энэ нь харааны бэрхшээлтэй хүүхдүүд орон зайн баримжаа олох, айдсаа даван туулах, нийгэмшихэд чухал ач холбогдолтой ажил болсон.



Дэлхийн банкны санхүүжилттэй «Бага боловсролын шинэчлэл» төслийн хүрээнд хараа, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29, 116 дугаар сургуульд 120.0 мянган долларын сургалтын тусгай хэрэгсэл нийлүүлсэн байна. Мөн нийслэлийн 25, 29, 55, 63, 70 дугаар сургуулиудад дээрх төслийн хүрээнд 30,0 мянган долларын хөрөнгө оруулалтаар тайвшруулах өрөө, өдөр өнжүүлэх анги, хөдөлмөрийн хичээлийн дадлагын танхимыг байгуулсан.





**Шигтгээ 2**

**Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэргэдэх “Нарны хаан хүүхдүүд” цэцэрлэг**

Монголын Хараагүйчүүдийн Үндэсний Холбооны дэргэдэх “Нарны хаан хүүхдүүд” цэцэрлэг нь 2016 онд байгуулагдсан. Манай цэцэрлэг бүрэн хараагүй, үлдэгдэл хараатай, сул хараатай, энгийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай бага насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөр, тусгай болон ганцаарчилсан хөтөлбөрөөр дамжуулан “би чадна” гэсэн итгэлтэй, зөв үйлтэй, зөв сэтгэлтэй хүүхдийг төлөвшүүлэх эрхэм зорилготой ажиллаж байна.

Цэцэрлэгийн багш нарын 50% нь харааны бэрхшээлтэй хүүхэдтэй ээжүүд ажилладгаараа маш онцлог.

Тус цэцэрлэг анх удаа эх орондоо харааны бэрхшээлтэй хүүхдийн IQ-г хөгжүүлэх зорилгоор Монголын оюун ухааны академитай хамтран спорт өрөлт, рубик шоо эвлүүлэх гэх мэт сургалтуудыг явуулах албан ёсны эрх аван ажиллаж байна. Мөн манай цэцэрлэг МХҮХ-гоор дамжуулан харааны бэрхшээлтэй хүүхдийн олон улсын Пэркинс сургуультай хамтран ажиллаж байна.

## НАЙМДУГААР БҮЛЭГ: ХҮРТЭЭМЖ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХҮРТЭЭМЖ

### Холбогдох хууль тогтоомж

Барилга, хот байгуулалтын салбарын бодлого, холбогдох хууль, тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 85 дугаар тушаалаар байгуулагдсан «Орон сууц» үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө» үндэсний зөвлөлийн төлөөлөл орж ажилласан. Уг хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлуулсан. Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор баталсан «150 мянган айл-Орон сууц» үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зорилт, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 125 дугаар тушаалаар баталсан «150 мянган айл-Орон сууц» үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 4.4.1, 4.4.2, 4.4.3-т зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тусгасан.

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дугаар тушаалын дагуу Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны төлөөлөл ажиллаж байна. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 153 дугаар тушаалаар Барилга байгууламжийн норм, нормативын сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчилж, “Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ-ын төлөөлөл ажиллах боллоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн хурлаар өгсөн чиглэлийн дагуу Хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл боловсруулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн тандалт, судалгааны ажил болон хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эхний хувилбарыг тус тус боловсруулаад байна. Уг хуулийн төслийн зорилго нь төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд оршиж байна.

Энэхүү хуулийн төслийн ерөнхий бүтэц:

- Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл;
  - Хоёрдугаар бүлэг. Барилга байгууламжийн хүртээмж;
  - Гуравдугаар бүлэг. Зам, тээврийн хүртээмж;
  - Дөрөвдүгээр бүлэг. Харилцаа холбооны хүртээмж;
  - Тавдугаар бүлэг. Хүртээмжтэй орчныг бүрдүүлэхэд төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг хариуцлага;
  - Зургадугаар бүлэг. Бусад зүйлийн талаар зохицуулна.
- Барилга, хот байгуулалтын яамнаас салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд “Хот байгуулалтын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 55 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлүүлсэн. Үүнд:
- “Хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах”
  - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн хэрэгцээг хангах нь хот байгуулалтын баримт бичигт тавигдах үндсэн шаардлага болох”
  - “гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй орчинг бүрдүүлэн төлөвлөсөн байх”
  - “Хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах аливаа төсөл, барилгажилтын шийдэл, зураг төсөлд зөвшөөрөл олгохгүй байх”
  - “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны талаарх мэдээлэл тусгах” зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн зүйл, заалтыг тусгаад байна.

Хүртээмжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Барилгын тухай, Хот байгуулалтын тухай хуулиудын дагуу Барилгын хөгжлийн төв нь хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх шатанд "Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм" /БНБД 30-01-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл төлөвлөлт" /БД 31-112-11/ болон холбогдох бусад норм, стандартын шаардлагыг хангуулан хянаж баталгаажуулан ажиллаж байна. 2019 оны 12 дугаар сарын байдлаар 21 хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 221 орон сууцны барилга, 691 орон сууцны бус барилга, 229 их засвар, 120 тохижилтын ажлын зураг төсөл, нийтдээ 1282 зураг төсөлд магадлал хийлээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилга байгууламжийн дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлын хүрээнд Барилгын хөгжлийн төвөөс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн эсэхийг хянаж, батлагдсан зураг төсөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох /БД 31-112-11/, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага /БД 31-101-04/-ыг баримтлан хяналт тавьж байна. 2019 оны байдлаар 487 төсөл арга хэмжээнд техник хяналтыг хэрэгжүүллээ.

- Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас 2019 оны 3 дугаар улирлын байдлаар орон сууцны зориулалттай 186 барилга байгууламжид улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус комиссын бүрэлдэхүүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын төлөөллийг байнга оролцуулан ажиллуулж байна.

- Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд шинээр баригдах орон сууцны хотхон, хорооллын барилга байгууламжийн орц, гарцад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан налуу зам, цахилгаан шатанд брайль үсгэн тэмдэглэгээтэй товчлуур, гадна авто машины зогсоолын 3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоол, хотхон, хорооллын доторх явган замыг хараагүй хүмүүст зориулсан товгор гадаргуутай хавтан бүхий зам, барилга байгууламжийн 1-р давхарын хонгилын хананд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул зэргийг барилгын зурагт заавал тусган төлөвлөх, түүнийг гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн нийтийн орон сууц, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарцны норм, стандартын талаар үзлэг шалгалтыг тогтмол явуулж байна.



- Барилга хот байгуулалтын яамны сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан "Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам"-аар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн түрээсийн квотыг хотод болон нутагт 5 хувь байхаар заасан. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 2484 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлснээс 129 айлын орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан нь нийт түрээслэгчдийн 5.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 14. Түрээсийн орон сууцанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо

№	Байршил	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
1	Улаанбаатар хот, “Хангай хотхон”	22
2	Улаанбаатар хот, “Буянт –Ухаа 2” хороолол /ТОСК/	43
3	Улаанбаатар хот, “Буянт –Ухаа 2” хороолол /НОСК/	30
4	Дархан-Уул аймаг	8
5	Увс аймаг	5
6	Ховд аймаг	7
7	Архангай аймаг	7
8	Хэнтий аймаг	5
9	Сэлэнгэ аймаг	2
<b>Нийт</b>		<b>129</b>



### ЗАМ, ТАЛБAYН ХҮРТЭЭМЖ

#### Холбогдох хууль тогтоомж

Зам, тээврийн салбарын хэмжээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дээшлүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчинг дараах байдлаар бүрдүүлж ажилласан. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 49 дүгээр тушаалаар “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын дагуу “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлыг зохион байгуулах байгууллага болон ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулдаг болсон.

2. Засгийн газрын 2019 оны 163 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 3.2.1-т “явганаар болон унадаг дугуйгаар зорчих, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийг замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцөлийг бүрдүүлэх” гэж тусган хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настан, бага насны хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

3. Нийтийн тээврийн үйлчилгээний 1207 тээврийн хэрэгсэл бүртгэлийн санд бүртгэгдсэнээс 56 нь буюу дөнгөж 4.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нам шалтай, зориулалтын шаттай байна. Цаашид нийтийн тээврийн үйлчилгээг хүртээмжтэй болгохоор “Төрөөс Автотээврийн салбарт баримтлах бодлого (2018-2026)”-ын баримт бичгийг Засгийн газрын 2018 оны 321 дүгээр тогтоолоор батлуулсан. Уг бодлогын баримт бичгийн 2.3.3.3-т “хэрэглэгчдэд хүртээмжтэй, эдийн

засгийн үр ашигтай тогтвортой, найдвартай, аюулгүй, хосолсон зорчигч тээврийн үзүүлдэг болох” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

4. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 283 дугаар тогтоолоор батлуулсан. Уг хөтөлбөрийн 2.2.3-т “Зорилтот бүлгийн иргэд /ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон яаралтай тусламж, үйлчилгээ авах шаардлагатай иргэн, 18 хүртэлх насны хүүхэд/ орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих нөхцөлийг бүрдүүлэх” асуудлыг тусган хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдийг яаралтай тусламж үйлчилгээ авахад агаарын тээврээр хөнгөлөлттэй зорчих эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

5. Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд замын хөдөлгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцохтой холбоотой 11.10-т “Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ бүхий замд чиглэлийн тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэл энэ дүрмийн 10.5-д “Уулзвар, гарцаар нэвтрэх хөдөлгөөн нь зөвхөн нэг чигт зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд жолооч баруун гар тийш эргэхийн өмнө хамгийн баруун, зүүн гар тийш буюу буцаж эргэхийн өмнө хөдөлгөөний тухайн чигийн хамгийн зүүн гар талын захад урьдчилан байр эзэлсэн байна.” гэж заасны дагуу байр эзлэхээс бусад тохиолдолд уг эгнээгээр байрлан явахыг хориглоно”<sup>4</sup>, 16.4-т “Жолооч замын аль ч хэсэгт цагаан таяг барьсан харааны бэрхшээлтэй хүнийг урьдчилан өнгөрүүлнэ” гэх мэт.

## МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖ

### Холбогдох хууль тогтоомж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд “Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх” гэсэн асуудлын хүрээнд төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, дэлгэц уншигч програм хангамж болон шинэ технологи, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй ашиглахад зориулан бар кодтой хэвлэх, сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр туссан.

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэсгийн 3.4.5-д “хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тусгасан.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2016 онд өргөн барьсан Өргөн нэвтрүүлгийн тухай хууль нь Улсын Их Хурлын чуулганы 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27-р зүйл буюу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид хориглох зүйл хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхсан агуулга бүхий нэвтрүүлэг, зар сурталчилгааг хориглосон ба мөн хөтөлбөрт тавигдах шаардлагад хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлгийн хувь хэмжээг тодорхойлж өгсөн.

9. Дээрх заалт нь суудлын такси болон «Хүүхэд тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл», «Тулгуур эрхтний бэрхшээлтэй хүн» таних тэмдэг бүхий тээврийн хэрэгсэл, мөн энэ дүрмийн 25.4-т заасны дагуу зорчих хэсгийн баруун гар талын захаар байрлан явах унадаг дугуй, мопедод хамаарахгүй.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ЯАМДЫН ДЭРГЭДЭХ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ОНЦЛОХ АЖЛУУД

Хүснэгт 15. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилт яамдад, 2019 оны жилийн эцсийн байдлаар

№	Яамд	Албан хаагчдын тоо	ХБ-тэй албан хаагчдын тоо	Хөдөлмөрийн тухай хуулийн 111-р зүйлийн хэрэгжилт /хувиар/	Үүнээс					
					Хараа	Хэл	Сонгол	Хөдөлгөөн	Сэтгэц	Бусад
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	120	0	0						
2.	Барилга, хот байгуулалтын яам	70	2	71.4				1		1
3.	Батлан хамгаалах яам	75	байхгүй	0						
4.	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам	109	байхгүй	0						
5.	Гадаад харилцааны яам	147	1	17.2						1
6.	Зам тээврийн яам	142	байхгүй	0						
7.	Сангийн яам	167	2	30.3	1			1		
8.	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	81	байхгүй	0						
9.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	119	3	63.8				2		1
10.	Хууль зүй, дотоод хэргийн яам	101	байхгүй	0						
11.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	107	1	23.8						1
12.	Эрүүл мэндийн яам	100	0	0						
13.	Эрчим хүчний яам	79	байхгүй	0						
<b>ДҮН</b>		<b>1417</b>	<b>8</b>	<b>15.8</b>		<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>0</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл, яамдын салбар зөвлөл

### ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний хүний эрхийг хангах дэд зөвлөл 2019 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор “Хэнийг ч орхигдуулахгүй байх” уриатай Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IV конгресс Улаанбаатар хотноо 2019 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгууллаа.

- Энэ удаагийн конгресст бүс нутгийн 34, бусад тивээс 9 орны нийт 700 гаруй төлөөлөгч оролцон “Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх хандлагаар дамжуулан тогтвортой нийгмийн

хөгжил, эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” сэдвээр хурал чууллаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн 2, 3 дугаар нэгтгэсэн тайлан боловсруулан 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж НҮБ-ын хүний эрхийн хороонд хүргүүлэв. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх үндэсний тайлан илтгэлээ хялбаршуулсан журмаар хэлэлцүүлэхийг 2017 онд тус конвенцийн хороонд мэдэгдэж, хүлээн зөвшөөрсөн бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын хэлэлцүүлсэн сүүдэр илтгэлд үндэслэн хорооноос ирүүлсэн асуултын хариулт нь Засгийн газрын илтгэлд тооцогдох болсон.

- Энэ хүрээнд тус хорооноос манай Засгийн газарт 54 асуултыг 2018 оны 10 дугаар сард ирүүлсэн бөгөөд хорооноос ирүүлсэн асуултын хүрээнд 2016-2019 оны 6 дугаар сар хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, цаашид хийх үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэсэн болно.

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах журмыг баталсан. Журмын дагуу дараах шилдгүүдийг тодруулан алдаршууллаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус шилдэг “Дэд зөвлөл”-өөр Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх дэд зөвлөл,
- “Шилдэг салбар зөвлөл”-өөр Баянхонгор аймгийн салбар зөвлөл,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад хүртээмжтэй шилдэг “Боловсролын байгууллага”-аар Хөвсгөл аймгийн “Ирээдүй XXI зуун” цогцолбор сургууль,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй “Эрүүл мэндийн байгууллага”-аар Цус сэлбэлт судлалын үндэсний төв,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй шилдэг “Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллага”-аар “Скай хайпермаркет ХХК”,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүртээмжтэй оны шилдэг “Төрийн болон төсөвт, орон нутгийн өмчит байгууллага”-аар Дархан-Уул аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газар,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй шилдэг “Хэвлэл мэдээллийн байгууллага”-аар “Монгол HD” телевиз,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө “Нийгмийн зүтгэлтэн”-ээр Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 2-р сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын ангийн багш Х.Пүрэвсүрэн,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний “Манлайлагч төрийн бус байгууллага”-аар Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл тус тус хүртлээ.

Ингэснээр тухайн онд хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр салбар бүрт хийгдсэн үйл ажиллагааг үнэлэх, шилдгээр шалгарсан байгууллага, хувь хүнийг алдаршуулж бусдад үлгэр жишээ болгон урамшуулах бөгөөд жил бүр уламжлал болгон зохион байгуулж байх юм. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй шилдэг бүтээн байгуулалт” төрөлд нэр дэвшихээр ирүүлсэн материалууд журманд заасан шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хангаагүй учир энэ удаад тодруулах боломжгүй байв. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлсэн дорвитой арга хэмжээ, үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах шаардлагатай юм.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэмшүүлэх талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мобиком корпораци ХХК-тай Хамтын ажиллагааны санамж бичгийг 2019 оны 12 дугаар сард байгууллаа. Санамж бичгийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг чадавхжуулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, ажлын байраар хангах, холбогдох байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах юм.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн анхдагч мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд Норвегийн тусламжийн байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих бэлтгэл төсөл”-ийн дэмжлэгтэйгээр Ховд аймагт туршилтын тооллогын ажлыг 2019 оны 2 дугаар сард зохион байгууллаа. Тоологч нарыг бэлтгэх сургалтыг 2 өдөр, мэдээлэл цуглуулах ажлыг 14 хоногийн хугацаатай зохион байгуулсан. Үзлэг, тооллогын үр дүнгийн талаарх мэдээллийг 2019 оны 4,7,12 дугаар сард зохион байгуулсан уулзалтаар холбогдох байгууллагууллагын төлөөллүүдэд танилцуулж, санал солилцов. Үндэсний статистикийн хорооны Хүн ам, өрхийн мэдээллийн санд суурилсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэд санг байгуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газарт хүлээлгэн өгөхөд бэлэн болсон. Тус газрын хувьд мэдээллийн санг байршуулах сервер худалдан авах, Хур системээс зөвшөөрөл авах, ҮСХ-оос иргэний мэдээллийг хүлээлгэн өгөх учир Мэдээлэл нууцлалын гэрээ байгуулах зэрэг ажлыг зохион байгуулж байна. Эдгээр ажлыг ирэх оны эхний хагас жилд багтаан зохион байгуулж дуусахаар ажиллаж байна.

- “Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал” сургалтыг 2019 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, харьяа байгууллага, сургуулийн өмнөх сургалтын байгууллага, их дээд сургууль, зочид буудал, аж ахуйн нэгж болон төрийн бус зэрэг нийт 38 байгууллагыг хамруулсан байна. 2020 онд төлөвлөгөөний дагуу зарим яамд болон харьяа байгууллагуудыг хамруулна.

- Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, үйлдвэрийг шинэчлэн зохион байгуулж, улсын төсөвт үйлдвэрийн газар болгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга, дүрмийн төслийг боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэхээр бэлтгэлийг хангалаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт хандлагыг сайжруулах сургалт, семинарыг ЖАЙКА-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог сайжруулах төсөл”-ийн хүрээнд 2 удаа зохион байгууллаа. Сургалтад давхардсан тоогоор 150 гаруй хүнийг хамруулав. Сургалт, семинарын үеэр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг яамд, салбаруудын бодлого, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж байгаа бусад орны туршлагын талаар танилцуулж, цаашид дэд зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар хэлэлцүүлэг хийж, зөвлөмж гаргасан. Сургалтын үеэр, дэд зөвлөлүүдийн хуралд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо хангалтгүй байна, хурал тогтмол явагдахгүй байна, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай зэрэг олон асуудлуудыг дэвшүүлэв.

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гарын авлага, сургалтын модуль боловсруулах ажлыг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Модулийн дагуу 21 аймаг, 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулав.

- НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Бээжин дэх төлөөлөгчийн газартай хамтран хөгжлийн бэрхшээлийн талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын модулийг боловсруулсан бөгөөд энэхүү модулийн хүрээнд “Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ба хөгжлийн бэрхшээл” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад телевиз, сонин, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын 30 гаруй төлөөлөл оролцлоо. Цаашид энэхүү сургалтыг тогтмолжуулан хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын хандлага ойлголтыг нэмэгдүүлэх замаар нийгэмд эерэг ойлголтыг бэхжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

- Монгол Улс “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци”-д нэгдэн орсон өдөр, “Хөгжлийн бэрхшээлийг эрт үед оношлох илрүүлэх өдөр”, “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрт оношлох, энэ чиглэлд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой сарын аяныг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Аяны хүрээнд өрхийн эмч, сувилагч нарын хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, оношлох талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлж, чадавхжуулах зорилгоор Нийслэлийн Эрүүл мэндийн газартай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 03-ны өдрүүдэд хооронд Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Сэргээн засах төвөөс “18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтад Чингэлтэй дүүргийн 19 хороодын өрхийн 70 эмч хамрагдав. Энэхүү сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, түүний ач холбогдол, хүүхдийн хэвийн өсөлт, хөгжлийн талаарх ойлголт, мэдээллийг өгөв.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд орох тэгш эрхийг хангаж хэрэгжүүлэх, хамгаалахтай холбогдсон үйл ажиллагааг салбар дундын зохицуулалтаар хангаж дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн гишүүдийг нэгдсэн байдлаар шаталсан хэлбэрээр богино хугацааны сургалтаар дамжуулан дохионы хэлний анхан шатны мэдлэгийг олгох сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус сургалтыг зохион байгуулснаар сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрх нь бүрэн хангагдаж, төрийн үйлчилгээнд цаг алдалгүй тухай бүр хамрагдах боломж нөхцөл нэмэгдэх, тулгамдаж буй асуудлыг шат шатанд нь шийдвэрлэхэд нөлөөлөх, төрийн байгууллага иргэд хоорондын уялдаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах ач холбогдолтой юм.



- JICA-тай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд “Дэд бүтцийн хүртээмжийн хяналтын системийг сайжруулах нь” сэдэвт төр, төрийн бус байгууллагуудын хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэхүү семинарын зорилго нь Монгол Улсад “Хүртээмжийн тухай хууль”-ийн төслийг боловсруулах салбар дундын ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яаман дээр байгуулагдсантай холбогдуулан ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангах, ойлголтыг нэгтгэх юм. Мөн Монгол Улсад байгаа барилгын зураг төсөл боловсруулах, хянах, барилга хүлээж авах комиссын хяналтын системтэй танилцан Япон улсын туршлагыг сонсож, хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцсэн юм. Уг хэлэлцүүлэгт төр болон төрийн бус байгууллагын нийт 120 гаруй хүн оролцсон бөгөөд Барилга, хот байгуулалтын яам болон Барилгын хөгжлийн төвөөс мэдээлэл хийж зураг төсөл боловсруулах болон барилга хүлээж авах хяналтын системийн талаар танилцуулга хийлээ. Хэлэлцүүлгээс Монгол Улсад ашиглагдаж байгаа барилга хүлээж авах болон барилга байгууламжийг үнэлдэг хяналтын хуудсыг шинэчлэх болов.

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бусад төрийн байгууллагад загвар болохуйц, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд төдийгүй бүх хүнд таатай, ээлтэй, хүртээмжтэй орчин бүрдүүлэх зорилгоор яамны барилга байгууламжид зарим засвар, өөрчлөлтийг хийлээ. Үүнд: Яамны 3 ариун цэврийн өрөөг хүртээмжтэй болгон шинэчлэн засварлаж, коридорт 50 гаруй метр тактелин зам, 100 гаруй метр ханын бариулыг шинээр хийсэн. Мөн яамны 2 хурлын заалыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгон засварлаж, тохижуулаад байна. Бүх өрөөний хаяг, давхрын мэдээллийг брайль үсгээр хийж, тэргэнцэртэй иргэдэд зориулсан өргөх төхөөрөмжийг байрлууллаа. Энэ ажилд яамны төсвөөс 100 гаруй сая төгрөгийг зарцуулсан бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэний үүсгэн байгуулсан “Ректус” компаниар гүйцэтгүүлсэн болно.

- 2018 оны 2 дугаар сараас эхлэн сар бүр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, төрийн бус байгууллагуудад зориулан “Мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулж ирсэн. 2019 онд нийт 8 удаагийн арга хэмжээг холбогдох төр, төрийн бус байгууллагуудын оролцоог ханган зохион байгуулсан. Мэдээллийн цаг арга хэмжээгээр яамдын дэд зөвлөлийн үйл ажиллагаа, шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төсөл, хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, түрээсийн орон сууц хөтөлбөрийн хэрэгжилт зэрэг үйл ажиллагааны талаар танилцууллаа. Төрийн бус байгууллагууд хууль тогтоомжийн шинэчлэл, арга хэмжээ үйл ажиллагааг цаг алдалгүй хүргэж байгаад нь талархалтай хандаж буйгаа илэрхийлж байгаа.

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг жил бүрийн 12 дугаар сарын 3-нд тэмдэглэдэг бөгөөд энэ онд “Хүртээмжтэй ирээдүй” уриан дор тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ хүрээнд сарын ажлын төлөвлөгөө гарган Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран 20 гаруй арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр job coach сургагч багш буюу ажлын байран дахь дадлагажуулагч бэлтгэх сургалт, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохирох хэрэглэгдэхүүний шинэ бүтээл оновчтой саналын уралдаан, эрдэм шинжилгээний хурал, оюутан залуучуудын дундын мэтгэлцээн, дохионы хэлний сургалт, ТВ хэлэлцүүлэг, мэргэжлийн ур чадварын тэмцээн зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

## **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар тус яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан болно.

Зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

-Тус яам болон харьяа байгууллагуудын хэмжээнд нийт 54 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байна. Уг судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, сүүлийн 2 жилд байгууллагаас үзүүлсэн тусламж дэмжлэгийн судалгааг авч, тус албан хаагчдыг ажлын богиносгосон цагаар ажиллуулахаар төлөвлөн ажиллаж байна. Мөн ямар ажлын байранд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажиллуулж болох талаар судалгаа хийж байна.

-Аялал жуулчлалын зориулалтаар тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулахаар хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжийн барилгажилтын стандартад Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан орц гарцны хүртээмжийн норм стандартад тус яамны зүгээс холбогдох төрийн байгууллагуудаас тодорхой зөвлөмж авч, санал солилцон хамтран ажиллаж байна.

-Аялал жуулчлалын салбарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих, тэдгээрийг байнгын орлогоор хангах чиглэлээр тур оператор компаниуд болон жуулчны баазуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гар урлалын бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж байна. Энэ хүрээнд Монголын аялал жуулчлалын холбоотой хамтран улсын хэмжээнд зохиогдож буй Аялал жуулчлалын арга хэмжээнүүдийн нэгдсэн хуваарь байршлын талаарх мэдээлэл болон зорчих үйлчилгэний төрөлжсөн сургалтын зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагуудад хүргүүлдэг болсон.

-Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж байгаа олон улсын санхүүжилттэй төсөл хөтөлбөрийн зохицуулагч нарт хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ТББ-ын санаачилсан байгальд ээлтэй, ногоон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хэрхэн хамтран ажиллах чиглэл өгч дэд зөвлөлийн хурлыг зохион байгууллаа.

-Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-уудын зүгээс зохион байгуулж буй урлагийн тоглолтын тасалбараас тодорхой тооны тасалбарыг худалдан авч үйл ажиллагааг нь дэмжин ажилласан болно.

-Тус яамны дэд зөвлөлийн зүгээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай зөвшилцөн Улаанбаатар хотод дахь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургалттай 10 жилийн сургуулийн гадна орчинд мод тарих ажлыг холбогдох төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа.

### БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний зөвлөл, Монголын дүлий иргэдийн Урчуудын холбоо, "Абаазан сан" төрийн бус байгууллагын төлөөлөл орж идэвх, санаачилгатай ажиллаж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хамгаалах өдрийг угтан БХБЯ-наас Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэний байгуулсан "Тулга тав" студитэй хамтран "Дэд бүтцийн хүртээмжтэй орчин" сэдэвт нэвтрүүлгийг бэлтгэн 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр МҮОНТ, MN/25-р суваг телевизээр, 10 дугаар сарын 25-ны өдөр UBS телевизээр тус тус цацаж олон нийтэд хүргэлээ. Энэ нэвтрүүлгээр холбогдох удирдлага, мэргэжилтнүүд оролцон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилга байгууламжийн норм, стандарт, дэд бүтцийн төлөвлөлт, бүтээн байгуулалтын талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тулгамдсан асуудал, цаашдын зорилтын талаар хэлэлцүүлэг хийлээ.

«Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө»-ний дагуу Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/, Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн төлөвлөлт / БНБД / , Сургуулийн өмнөх боловсролын барилгын зураг төсөл төлөвлөх /БНБД/, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх /БНБД31-01-10/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилга байгууламжийн хүртээмжтэй байдал /БД31-101-04/, Эмнэлгийн байгууллагын барилга, өрөө тасалгааны зураг төсөл төлөвлөх /БНБД/, Олон нийт, иргэний барилга /БНБД31-03-03/, Олон төрлийн зориулалттай барилга / БНБД/, Үзвэр үйлчилгээ, театрын барилга байгууламжийн төлөвлөлт /БНБД/, Зочид буудлын барилга төлөвлөлт /БНБД/ зэрэг норм, нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж байна.

Түүнчлэн Барилга, хот байгуулалтын яам болон Барилгын хөгжлийн төвийн захиалгаар “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-ноос “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй, хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламжийн төлөвлөлтөд тавигдах шаардлага” нормативын баримт бичгүүдийг нийтэд сурталчлан таниулах анимейшныг бэлтгэх ажлыг хийлгэн нийтийн хүртээл болголоо.

Мөн «Барилга байгууламжийн норм, нормативын сангийн үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө»-ний дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй саадгүй орчныг бүрдүүлэх зөвлөмжийг цахим хэлбэрт оруулах” ажлыг эхлүүлээд байна.



Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, номхон далайн 4 дүгээр конгрессыг зохион байгуулахтай холбогдуулан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг”-ийг шалгаруулах журмын 4.1.6-д заасныг баримтлан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт” төрөлд нэр дэвшүүлэн тодорхойлох ажлыг зохион байгуулсан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Дэд бүтцийн хүртээмжийг бодитоор сайжруулах тухай” семинарт Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв /ТӨААТҮГ/ болон зураг төслийн экспертийн төлөөлөл оролцов.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ажиллах, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээний чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас санаачлан Монгол Улсад анх удаа харааны бэрхшээлтэй иргэд, сурагчдад зориулсан 4 төрлийн брайль газрын зургийг зохион, хэвлүүлээд харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн сурагчдын газар зүйн хичээлийн сургалтын хэрэгцээнд зориулан тус бүр 150 ширхэгийг хүлээлгэн өгөв. Үүнд:

1. Дэлхийн газрын зураг;
2. Монгол орны засаг, захиргааны зураг;
3. 116 дугаар сургууль орчмын тойм зураг;
4. 116 дугаар сургуулийн хашаан доторх тойм зураг зэрэг болно.



Брайль газрын зургийг харааны бэрхшээлтэй сурагч, иргэдийн онцлог, тэдний мэдлэг, мэдээлэл олж авах хэрэгцээнд нийцүүлсэн бөгөөд хараагүй иргэдэд зориулан газрын зургийн шугаман элементийг товойлгон дүрслэх байдлаар, нэрийг брайль бичгээр бичиж, харин сул хараатай сурагч, иргэдэд зориулан өргөн зураас, том үсгээр дүрсэлсэн.

Эдгээр брайль газрын зургаар дамжуулан сургуулийн ойр орчмын газар орны байдал, өөрийн улсын болон аймгуудын байршил, хэлбэр, хэмжээ, дэлхийн улс орнууд, тив, далай тэнгис хаана байрлаж байгааг мэдэж авч, газар зүйн мэдлэгээ нэмэгдүүлнэ. Харааны бэрхшээлтэй сурагчид нь брайль газрын зураг ашиглан автобусны буудлаас сургууль хүртэл ирж, мөн сургуулийн хашаан дотор ганцаараа ч явах боломжтой боллоо. Цаашид аймаг, сум, Улаанбаатар хоттой илүү их ойр танилцах боломж олгохоор Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас “Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Монгол орны атлас” зохиож, хэвлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

### БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Батлан хамгаалах яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 95 хувьтай байна.



Дэд зөвлөлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу яамны харьяа байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээ зохион байгуулах чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

-Яамны зүүн хаалганы гадна талын тэргэнцэртэй хүний замыг төгрөг стандартад нийцүүлэн засварлахад 4,3 сая төгрөг зарцуулсан юм.

-Салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран өсвөр насны хөгжлийн бэрхшээлтэй 10 хүүхдийг “Хүндэт харуул”-ын гэх тодотголтой Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн болон хүндэт харуулын үйл ажиллагаатай 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр танилцуулсан. Энэ ажлыг цаашид уламжлал болгон үргэлжлүүлэн зохион байгуулахаар төлөвлөж байна.

Батлан хамгаалах яамны харьяа байгууллагуудын зарим ажлаас дурдвал:

Цэргийн төв эмнэлэг нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хууль, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн холбогдох заалт, Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмчийн 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн А/82 дугаар тушаал болон бусад холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг хангах, тус эмнэлэгт ажил, үйлчилгээ явуулж байгаа болон үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллах, үйлчлүүлэх нөхцөл, боломжийг сайжруулах, тэднийг нийгмийн бүхий л харилцаанд оролцох, ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд ээлтэй эрүүл нийгмийн орчныг бүрдүүлэх зорилго тавьж ажилласан.





-Хөтөч сувилагчийг дохионы хэлний сургалтад хамруулах зардлын асуудлыг шийдвэрлэн, боловсон хүчнээ бэлтгэхээр ажиллаж байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус эмнэлгээр дугаар харгалзахгүй үйлчлүүлдэг болсон.

-Тус эмнэлэгт одоогийн байдлаар нийт 7 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангаад байна.

-Засгийн газраас санхүүжүүлдэг мэргэшлийн сургалт болон бусад ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэхээр Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйл, 79 дүгээр зүйлийн 79.3 дахь заалт, 111 дүгээр зүйлийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

-Японы олон улсын хамтын ажиллагааны “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийн 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтын талаарх мэдээллийг “Цэргийн төв эмнэлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-д тусган “Өнөөдөр нөлөөлж, Маргааш өөрчлөө” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан.

-Цэргийн төв эмнэлгээр нийт хэвтэн эмчлүүлж, тусламж үйлчилгээ авсан 2019 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 752 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

-Амбулаторийн нэг давхрын 00-ын нэг өрөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тохижуулав.



-Мөн яаралтай тусламж хүлээн авах тасаг руу гадна талаас нэвтрэх тэргэнцэр, дугуйт хэрэгслийн замын чиглэлийг өөрчлөх, налуу хэсгийг стандартад заасны дагуу тохижуулж, 8 ш тэргэнцэрийг шаардлагатай үед ашиглахаар бэтгэсэн.



-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийг тохиолдуулан нийслэлийн 29 дүгээр сургуулийн сурагчдад урьдчилан сэргийлэх үзлэг хийж, урлагийн тоглолт үзүүлж, үдийн цай арга хэмжээг зохион байгуулсан.



-Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэл яриа, хөдөлгөөн засалын буланг Сэргээн засах, нөхөн сэргээх тасгийн дарга дэд хурандаа В.Ундрамын санаачилгаар хийж гүйцэтгэсэн.



Үндэсний батлан хамгаалах их сургууль нь батлан хамгаалах салбарт ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эхээс гаргасан өргөдлийг судалсны дагуу элсэлтийн шалгалтын журмыг хангасан 2 сурагчийг суралцуулж байна.

Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга нь "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бие эрхтэн, хөгжлийн онцлогт нийцсэн ажлын байрыг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу бий болгож, ажиллуулах үүрэгтэй" гэсэн заалтын дагуу 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнийг ажиллуулж байна.

-Монгол цэргийн өдөрт зориулж Зэвсэгт хүчний 98 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтонд зорилтот бүлгийн 50 иргэнийг урилгаар үзүүлсэн.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг аюулгүй, цэвэр таатай орчинд үйлчлүүлэхэд зориулж ариун цэврийн өрөөний крантанд тулгуур хийж, суултуурын дэргэд бариул хийсэн.

-Гадна хаалганы өгсөх уруудах шатны хэсэгт унахаас сэргийлсэн 2 бариул хийж, тэргэнцэртэй иргэдийг саадгүй зорчиход зориулсан замыг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.


-Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангах, урлаг соёлын үйлчилгээ, Зэвсэгт хүчний тухай мэдээ мэдээллийг хүргэх зорилгоор "Дуулга" студийн бэлтгэдэг "Эх орны төлөө" нэвтрүүлгийг дохионы болон брайль үсгэн тайлбартайгаар үзэгчдэд хүргэсэн зэрэг ажлуудыг хийж хэрэгжүүлсэн.

-Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг тохиолдуулан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулга, Цэргийн төв эмнэлгээс санаачилан, Монгол цэргийн музейтэй хамтарч Нийслэлийн ерөнхий боловсролын 70 дугаар тусгай сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад зориулсан хамтарсан өдөрлөгийг зохион байгууллаа.



Энэхүү өдөрлөгийн хүрээнд Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчид талархлын тоглолтоо толилуулсан бөгөөд цэргийн нэгдсэн төв эмнэлгийн хамт олон өдөрлөгт оролцож буй сурагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд хамруулж, Монгол цэргийн музейн хамт олон цэргийн түүхийн ертөнцөөр аялуулсан.

Монгол цэргийн музей нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тогтмол төлбөргүй үйлчилж, ая тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл бололцоог ханган ажиллаж байна. Энэ хүрээнд музейн үзмэрийн танхимуудын товч тайлбар, мэдээллүүдийг багцлан Нийслэлийн 116 дугаар тусгай сургуультай хамтран сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан дохионы хэлний тайлбар, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль үсгэн тайлбарууд бэлтгэн хийх, шинэчлэх, баяжуулах ажлуудыг хийж байна.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг музей үзэхэд хүндрэл учруулахгүй байх, тав тухтай орчныг бүрдүүлэхийн тулд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:





-Музейн үзүүлэнгийн танхимуудын шилэн хоргыг тэргэнцэртэй иргэдийн харааны түвшинд байлгахын тулд нэг стандарт хэмжээнд засварлаж, үзүүлэг дэглэлтийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаад байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат, дотор талд орж гарахад саадгүй нэвтрэх тусгай замыг, мөн тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдэд зориулсан 2 ширхэг тусгай тэргэнцэрийг ашиглаж байна.



Нийслэлийн 116 дугаар тусгай сургуулийн сурагчдад музейн үзүүлэгийн танхимуудад “Эртний монголчуудын зэр зэвсэг” сэдвээр боловсролын ажил зохион байгуулж ажилласан. Тус сургуулийн 5 дугаар ангийн 20 сурагч, багш, эцэг эхийн хамт боловсролын ажилд хамрагдлаа. Сурагчдад үзүүлэгийн танхимын тайлбаруудыг брайль үсгээр уншуулж, үзмэр, эд өлгийн хуулбарыг өгсөн ба сурагчид хүрч мэдэрснээр тухайн үзмэрийн хэлбэр дүрсийг төсөөлөх, танин мэдэх зэрэг бодит ажлыг зохион байгуулсан.



-Баянзүрх дүүргийн 55 дугаар сургуульд суралцаж байгаа оюуны хөгжлийн бэрхшээлтэй, Дауны хам шинж, аутизмтай 200 гаруй бага ангийн сурагчдыг дөрөвдүгээр сар, тавдугаар сарын эхний 7 хоногт зохион байгуулалттайгаар Монгол цэргийн музейг товч тайлбартай үзүүлсэн.

-Музейн эртний түүхийн танхимын үзмэрүүдийн хуулбарыг байршуулж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдөр буюу 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Баянгол дүүргийн 70 дугаар тусгай сургуулийн 8 дугаар ангийн 27 сурагчид үзмэрүүдийг барьж үзэх, хүрч мэдрэх, танин мэдүүлэх зэрэг ажлуудыг амжилттай зохион байгуулсан.

## **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх ажлууд 98%-тай биелэгдсэн байна.

2019 оны 10 дугаар сард БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын санаачлагаар “Тусгай хэрэгцээт боловсролын асуудал, шийдэл” согог зүйч багш нарын уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад Нийслэлийн боловсролын газар, Боловсролын хүрээлэн, ерөнхий боловсролын сургуулийн согог зүйч мэргэжлийн багш нар оролцож тусгай хэрэгцээт боловсролын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон.

Уулзалтад оролцсон багш нар тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн боловсролын асуудалд зөвлөн туслах “Мэргэжлийн зөвлөл” байгуулах, ерөнхий боловсролын сургуулийн багш нар болон одоо ажиллаж байгаа согогзүйч багш нарыг давтан сургалтад хамруулах зэрэг олон ажлуудыг хамтран хийхээр төлөвлөн хэрэгжүүлж байна.



Монголын хүүхдийн спортын YI наадмын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дунд

Паралимпийн төрөлд:

1. Хонхот бөмбөгийн төрлөөр 31 хүүхэд
2. Пара жү-до 34 хүүхэд
3. Пара хөнгөн атлегикийн гүйлтийн төрөлд 13 хүүхэд
4. Пара Бочигийн төрөлд 25 хүүхэд

Диплимийн төрөлд:

1. Сагсан бөмбөгийн төрөлд -65 хүүхэд
2. Ширээний теннисний төрөлд- 31 хүүхэд
3. Хөнгөн атлегикийн гүйлтийн төрөлд 44 хүүхэд

Тусгай олимпын төрөлд:

1. Ширээний теннис- 24 хүүхэд
2. Волейбол- 40 хүүхэд
3. Жү-до- 29 хүүхэд тус тус оролцсон.

Монголын хүүхдийн спортын YI наадмын хүрээнд өвлийн спортын тэшүүрийн төрлөөр Ерөнхий боловсролын тусгай 25, 63, 55, 70 дугаар сургуулийн Дауны бэрхшээлтэй 65 хүүхэд оролцсон.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Олон улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 9 дүгээр сарын 14-ны өдрийг Монголын Паралимпийн Үндэсний өдөр болгон зарлаж Паралимпийн аварга, медальтнуудыг сурталчилах арга хэмжээг Үндэсний дуурь бүжгийн эрдмийн теарт зохион байгуулж нээлтийн арга хэмжээнд Азийн Паралимпийн гүйцэтгэх захирал Тарек Сүэль тэргүүтэй төлөөлөгчид болон тусгай сургуулийн сурагчид, Паралимп, Дифлимп, Тусгай олимпын баг тамирчид нийт 300 гаруй хүүхэд оролцсон. Хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд спортын төрлийг сурталчилах 3 төрлийн спортын арга хэмжээг зохион байгуулсан.

Спортыг дэмжих сангаас Монголын Тусгай Олимпын Хорооны "Хамтарсан фитнес" төсөл хөтөлбөрт 40.0 сая төгрөг, Монголын Тэргэнцэртэй сэлэмний холбооны "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтийн биеийн тамир, спортыг тэргэнцэртэй сэлэмний спортоор дамжуулан сурталчлах хөтөлбөр"-т 21.500 сая төгрөг, Монголын Пара гүйлтийн цана, биатлоны нэгдсэн холбооны "2022 оны Өвлийн Паралимпийн наадмын эрх авах бэлтгэл цугларалт, тэмцээнд оролцох" хөтөлбөрт 40,0 сая төгрөгийг зарцуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн төлөвлөгөөний дагуу Дүрслэх урлагийн музейд тайлбарыг сонсох боломжтой аудио гайдаас гадна сонсголын бэрхшээлтэй хүмүүс таблет ашиглан QR кодыг уншуулж үзмэрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг унших боломжийг бүрдүүлсэн. Одоогийн байдлаар Эртний урлаг, Ардын урлаг танхимуудад ашиглагдаж байгаа бөгөөд бүх танхимуудад нэвтрүүлэхээр ажиллаж байна. Мөн ХХ зууны алдарт бүтээл Монголын нэг өдөр бүтээл зургийг хөдөлгөөнт хэлбэрт оруулсан нь ямар ч насны үзэгчдэд сонирхолтой контент болсон. Тус зургийн зарим хэсгийн үйл явдлууд хөдөлгөөнд орох ба зурагт болох үйл явдлын дуу, чимээ гардагаараа онцлогтой юм. /хонь, ямаа майлах, морь янцгаах, бөөгийн хэнгэргийн чимээ гэх мэт/ Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд зөвхөн бусдаар дамжуулж, тайлбарлуулж авдаг байсан уран зургийн тухай мэдрэмжийг өөрийн биеэр мэдрэх боломжийг бүрдүүлж өгснөөрөө бүх үзэгчдээ соёлын үйлчилгээнд тэгш хамруулах боломжоор хангагдаад байгаа юм.

"Хүүхэд, залуучуудын уншлагыг дэмжих аян"-ны хүрээнд хүүхдийн зохиолч О.Сундуйтай уран бүтээлийн уулзалт хийж харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн бага бүлгийн нийт 70 сурагчийг хамруулан унших хүсэл тэмүүлэл, номны тухай ойлголтын талаар зорилтот ажил хийв. Тэргүүний уншигч шалгаруулах "Д.Нацагдорж тэмдэг"-ийн болзолыг Харааны бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 5"А" ангийн сурагч хангаж, тэргүүний уншигчийн тэмдэг үнэмлэхээ гардан авлаа. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэр дээр 11 удаа 57 хүнд 84 номоор зөвөөр уншлага, Налайх дүүргийн соёлын ордны номын сантай 10 удаа 31 брайль номоор солилцоо хийж хамтарч ажиллалаа. "Туслагч технологийн сургалт"-ыг 4 удаа зохион байгуулж, нийт 210 хүн хамрагдсан. Үүнд:

-Дэлхийн брайлийн өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 80 хүн

-Дэлхийн номын өдөрт зориулсан үйл ажиллагааны хүрээнд DAISY ном тоглуулагч төхөөрөмж, цахим брайль төхөөрөмж танилцуулах сургалт - 116-р сургуулийн 30 гаруй хүүхдүүд эцэг эхийн хамт

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 1-5-р ангийн сурагчдад зориулан DAISY цахим ном тоглуулагчийн сургалт - 70 гаруй хүүхдүүд багш нарын хамт

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 116-р сургуулийн 6-12-р ангийн сурагчдад зориулсан сургалт – 30 хүүхэд

-“Туслагч технологийн сургалт”-ыг мөн ганцаарчилсан байдлаар харааны бэрхшээлтэй 4 хүүхэд тус тус 7 удаа нийтдээ 28 удаа зохион явуулсан.

### **ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор тухай бүр хуралдаж, зам, тээврийн хөгжлийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулж ажилласан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хот байгуулалтын болон Барилгын тухай хууль тогтоомжийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамнаас санаачлан “Дөрвөн бэрх хөгжил сан” ТББ-тай хамтран Нийслэлийн ерөнхий боловсролын 29, 116 дугаар тусгай дунд сургууль болон 186 дугаар тусгай цэцэрлэгийн гаднах орчныг стандартын дагуу тохижуулж, машины зогсоол, 700 м<sup>2</sup> асфальтан зам, явган хүний эко хавтан зам, гэрэлтүүлэг, хашааны хаалга, сагсан бөмбөгийн талбайг тохижуулах зэрэг 100 гаруй сая төгрөгийн эхний ажлаа 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн.



Автотээврийн үндэсний төв болон “Монголын тэргэнцэртэй иргэдийн холбоо” ТББ-тай хамтран нийтийн тээврийн хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор бага оврын автобусыг өөрсдийн зардлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тоноглон тохижуулж Төрийн өмчийн хорооны 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 431 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт хүлээлгэн өгөөд байна.



2019 онд Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрлэсэн нийт 1.827.000 төгрөгийн дугтуйг худалдан авсан байна. Мөн Нийтлэг үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх байгууллагаас 2018 онд архивын бичиг хэргийн бор цаас худалдан авч нийт 1.960.000 төгрөгийн орлого оруулж хамтран ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3-т “нийтийн

зориулалттай үйлчилгээний болон бусад байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дараалал харгалзахгүй үйлчлэх” гэж заасны дагуу Нийслэлийн “Лавай” автобуудал, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн зорчигч тээврийн төв болон орон нутгийн автотээврийн төвүүд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөн шуурхай дугааргүй үйлчлэх “Тусгай цонх” гарган ажиллаж байна.

Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний автобусанд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, 0-3 насны хүүхэдтэй хүмүүс, жирэмсэн эхчүүдэд зориулсан суудлын таних тэмдгийг автобусны 1, 2 дугаар суудалд байршуулсан бөгөөд www.transdep.mn сайтад байрлах онлайн тасалбар захиалгын системд уг суудлыг сонгох боломжийг олгосон.

Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн зорчигч тээврийн төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан “Амрах өрөө” болон үйлчилгээний танхимд үйлчлүүлэхэд саадгүй байх урсдаг шатыг хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх боломжоор хангагдсан.

“Улаанбаатар төмөр зам” вокзалын амрах байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай өрөө гаргаж тохижуулсан ба Замын-Үүд, Сүхбаатар өртөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бие засах өрөөг стандартын дагуу тохижуулж, Сүхбаатар, Зүүн хараа, Замын-Үүд вокзалуудад үүдний хэсэгт налуу шатны налуу хийж, бариул суурилуулж хүртээмжтэй орчинг бүрдүүлэхэд анхаарч ажилласан.

Зам, тээврийн салбарт Хөдөлмөрийн хуулийн 111 дүгээр зүйлийг дараах байдлаар хэрэгжүүлсэн байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Ажиллаж буй ХБИ-н тоо	Тайлбар
1.	Иргэний нисэхийн ерөнхий газар	12	
2.	“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ	11	Улаанбаатар болон орон нутгийн авто тээврийн төв, салбаруудад ХБИ-нийг ажлын байраар хангасан.
3.	“Чингис хаан” Олон улсын нисэх буудал	8 /+1/	Зуны цагийн ачаалалтай нислэгийн үеэр 1 ХБИ авч ажиллуулсан.
4.	Монгол-Оросын “Улаанбаатар төмөр зам” ХНН	143	2019 оны 10 дугаар сарын байдлаар Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст 73.152.000.00 /далан гурван сая нэг зуун тавин хоёр мянга төгрөг/ төлсөн.
5.	“Монголын төмөр зам” ТӨХК	6	Төмөртэйн өртөөнд 3, Дорноговь аймгийн Зүүнбаян багт байрлах Шуурхай удирдлагын төвд 2, Инженер технологийн хэлтэст 1
Нийт		181	

Цаашид дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагын оролцоог хангах, зам талбай, нийтийн тээврийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг шинэчлэн боловсруулах, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байраар хангах ажлыг эрчимжүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн сайдын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/47 дугаар тушаалаар батлуулав.

Дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дараах ажил хийгдсэн байна:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2018 оны 09 дүгээр 04-ний өдрийн 128 дугаар зарлигийн дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай” 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд сайдын зөвлөлийн хурлаар танилцуулахаар бэлтгэж байна.

-Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газрын нэтгэсэн дүн мэдээгээр 2017 онд 162 аж ахуйн нэгжийн нийт 18599 ажиллагсдын 2% буюу 296, Ашигт малтмал газрын тосны газарт 2 буюу нийт 298 хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж байна. Үүнд:

- Харааны бэрхшээлтэй 26
- Ярианы бэрхшээлтэй 15
- Сонсголын бэрхшээлтэй 78
- Хөдөлгөөний бэрхшээлтэй 55, бусад хэлбэрийн 124 хүн байна.

- Уг тоо баримтад үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газар хамтран салбарт ажиллаж болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны судалгааг хийв. Судалгаанд иргэдийг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр ангилан нийт давхардсан тоогоор 69 ажлын байрны урьдчилсан судалгааг гаргав.

-Бичил уурхай дахь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг таслан зогсоох, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор салбарын сайдын "Хүний эрх, хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжиж ажиллах тухай" 2018 оны 06 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын нийгмийн зөвшлийн 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 2.12 дахь заалтад "Аж ахуйн нэгж бүр Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтыг хэрэгжүүлж ажиллана" гэсэн заалтыг нэмж тусган Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр уг хэлэлцээрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлсэн.

-Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1, 111.2 дахь заалтын хэрэгжүүлэх зорилгоор Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан хайгуулын болон ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах зааврын 12 дугаар маягтад өөрчлөлт оруулж хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүний судалгааг аж ахуйн нэгжүүдээс авч мэдээллийн сан үүсгэн ажиллаж байна.

## **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл, түүний ажиллах журмыг баталсан. 2019 онд 18 үйл ажиллагааны хүрээнд 35 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

-Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, цалин хөлс, нөхөн олговор авах, хөдөлмөр эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний 12 агентлаг, байгууллагад 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй 87 албан хаагч ажиллаж байна.

-Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Хараагүйчүүдийн хөдөлмөр сургалтын үйлдвэрээр 1500 ширхэг цаасан дугуйг захиалан худалдан авч албаны хэрэгцээнд ашиглаж байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийтлэг тохиолддог эрх зүйн асуудлаар сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулж байна. Дурдсан хугацаанд нийт 30 орчим сургалт, уулзалтыг зохион байгуулж 1500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургалтад хамруулаад байна.

-Эрх зүйн сургалт, сурталчилгааны агуулга бэлтгэх, түгээх, ажлын нэгдсэн арга зүй, шалгуур үзүүлэлт, үр дүнг тооцох аргачлал, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан эрх зүйн мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, гарын авлага, DVD, Эрх зүйн хөтчийн гарын авлага, Эрх зүйн хөтчид зориулсан гарын авлагын шинэ номын мэдээг бэлдэж [www.legalinstitute.mn](http://www.legalinstitute.mn) цахим хуудсанд оруулсан.

-Иргэдийн эрх зүйн мэдлэг олгоход чиглэсэн бодит кейст тулгуурласан хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан 15-20 минутын богино хэмжээний 9 теле цувралкиног дохионы хэлмэрчийн орчуулгатайгаар бэлтгэн олон нийтэд түгээх ажлыг хийсэн.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 12 агентлаг, байгууллагад ажиллаж буй дохионы хэлний хэлмэрч, хөтчийн нэгдсэн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэсэн. Тус салбарт 2019 оны эхний хагас жилийн байдлаар 119 албан хаагч дохионы хэлний хэлмэрч, хөтчөөр бэлтгэгдсэн байна.

-“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах хөтөч цагдаа бэлтгэх нь” сэдэвт ахисан шатны 24 цагийн модуль сургалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран 2 удаа зохион байгуулж, 60 алба хаагчийг хамруулсан.

-Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагуудын шинээр ашиглалтанд орж байгаа барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох, гарах, үйлчлүүлэх зориулалтын зам, тусгай тэмдэглэгээ, зорчих хэсэг, налуу шат зэргийг хийж гүйцэтгэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд

үйлчлэх нөхцөлийг ханган ажилласан.

-Тус салбарт 2019-2020 онд шинээр баригдсан 10 барилгыг "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" Үндсэн шаардлага / MNS6055:2009/, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 256 дугаар тушаалаар баталсан "Барилгын норм ба дүрэм"-д заасан стандарт, шаардлагад бүрэн нийцүүлсэн.

-Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн утасны дугаарын бүртгэлийн санг шинэчлэх зорилгоор Монголын сонсголгүй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоотой 2015 онд байгуулсан хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг шинэчлэх саналыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. Үүний дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газартай хамтран "Санамж бичиг"-ийг шинэчлэн байгуулсан.

-Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн "Цагдаагийн мэдээлэл" нэвтрүүлгийг сонсголын бэрхшээлтэй иргэдэд хүргэх зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дохионы хэлний орчуулагчтайгаар гаргаж эхэлсэн. Тус бүр нь 15 минутын 63 дугаар 854 удаа 13359 минутын, бусад 41 удаагийн нэвтрүүлэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 66 шторк, 9 санамжийг олон нийтэд хүргэж, байгууллагын веб сайт, иргэдийг хүлээн авах танхимын дэлгэцээр гарган ажиллав.

Мөн дээрх мэдээллүүдийг давхардсан тоогоор 47 телевиз, 3 Fm радио, 8 цахим сайт зэрэг хэвлэл, мэдээллийн байгууллагад хүргүүлж, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.

-Гадаадын иргэн, харьяатын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж байгууллагын нөөцөд буй холбогдох хууль тогтоомжийг сурталчилсан 5 видео санамж мэдээллийг дохионы хэлээр орчуулан дүрс бичлэгийг байгууллагын үйлчилгээний танхим дахь дэлгэц болон цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэж байна.

-Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулсан "Нэг зүрх-нэг нийслэл" аянд нийслэл, дүүргийн Улсын бүртгэлийн газар, хэлтсүүд оролцож, бүртгэлийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.

-Цагдаагийн ерөнхий газар нь Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2018, 2019 онд зохион байгуулсан ажил, үйл ажиллагааны тайлан, зөвлөлийн хурлын талаарх мэдээлэл, зөвлөмж, санамж, үндэсний чуулганы мэдээлэл, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй оны шилдэг" шалгаруулсан тухай мэдээллүүд, "Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо"-ны фэйсбүүк цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг тус тус байгууллагын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) цахим хуудаст байршуулсан.

-Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 27-ны өдрийн хооронд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах хөтөч-цагдаа бэлтгэх нь" сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтын талаарх мэдээллийг Хэвлэл мэдээллийн төвийн болон бусад сайт, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.

Цаашид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангах, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх дэд зөвлөлийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын цахим хуудсуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох тал дээр анхаарч, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр бүтээлч, санаачилгатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## **ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Засгийн газрын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 418 дугаар тогтоолоор "Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдсан. Тус хөтөлбөрийн 4.4.4-т "салбарын хэмжээнд ажиллаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, борлуулах цэг бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх", 4.4.5-т "өнчин болон хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны залуусыг ахуйн үйлчилгээний салбарт ажиллах боломжийг дэмжих" гэж тусгагдсан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг



хангах орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтын сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуультай хамтран зохион байгуулав. Сургагч багш нар нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төсөл боловсруулах, бизнесээ төлөвлөхөд дэмжлэг үзүүлж, сургалт мэдээллийн арга хэмжээг тогтмол явуулах зорилготой. Ингэснээр хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, хөнгөлөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ. Сургалтанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнес инкубатор төв, Түгээмэл хөгжил” төв, Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, “Элэгсэг оршихуй” төрийн бус байгууллага, Арга билэг, Тулга тав зэрэг 10 гаруй төр, төрийн бус байгууллагуудын төлөөлөл хамрагдлаа.



БНХАУ-ын Өвөр монголын Өөртөө засах орны Хөх хот болон Улаанцав хотноо зохион байгуулагдсан «Монгол-Хятадын экспо-2019» сэдвээр гурав дахь удаагаа болсон олон улсын үзэсгэлэнд 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг бүртгэлийн хураамжаас чөлөөлж, хөнгөлөлттэй нөхцөлөөр оролцох боломжоор хангасан. Үзэсгэлэнд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд бараа бүтээгдэхүүнээ танилцуулж борлуулсан.

Мөн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан бусад дотоод, гадаадын үзэсгэлэн худалдаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бараа бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг сайжруулах зорилгоор тогтмол оролцуулж байна.

“Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бизнесийг дэмжих чиглэлээр 267 сая төгрөгийн зээлд 135 сая төгрөгийн батлан даалт олгоод байна.

Цаашид бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагааг дэмжих, ажлын байр, борлуулалтыг сувгийг нэмэгдүүлэх чиглэлээр бодитой арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн мэдээлэл, үйлдвэрлэл буй бараа бүтээгдэхүүний мэдээллийг нэгтгэх болон мэдээллийн сангаар дэмжлэг шаардлагатай зорилтот бүлгийн эрэлтийг тодорхойлж, шаардлагатай дэмжлэгийн хэлбэрийг тодорхойлох зэрэг асуудлууд тулгамдаж байна.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/229 дүгээр тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчилсэн бөгөөд 16 үйл ажиллагаа төлөвлөж, биелэлт 90 хувь байсан.

Дэд зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах нийт 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

Сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээний чиглэлээрх эрх зүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлсэн. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандарт, журам, заавруудыг шинэчлэн батлуулсан. Сэргээн засах тусламж, үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжид үндэслэн 2020-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус байгууллагын уялдаа холбоог сайжруулах чиглэлээр салбар дундын техникийн ажлын хэсэг байгуулан идэвхтэй ажилласан. Энэхүү ажлын хэсгүүд нь сэргээн засах тусламж, үйлчилгээ, ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний чиглэлээр амжилттай хамтран ажилласан.

Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоотой хамтран хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалтын гарын авлагыг боловсруулж байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй эрүүл мэндийн байгууллагаар шалгарсан нь жишиг үйлчилгээг бий болгож манлайлсан.

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Эрчим хүчний сайдын 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 07 дугаар тушаалаар Эрчим хүчний яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах эрчим хүчний салбарын орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулж ажилласан байна.

Эрчим хүчний яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Эрчим хүчний салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан салбарын бүх байгууллагуудад төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллуулах тухай албан тоотыг хүргүүлэн ажиллав.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 291 дүгээр тогтоолоор “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус дүрмийн 5.3 дахь хэсэгт төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх нөхцөлийг тусгаж, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай хэрэглэгчдэд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлж байна.

Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар тусгай бүлэг заалтыг оруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалин хангамж нэмэгдэж компанийн бага тушаалын албан хаагчийн цалингийн хэмжээнд хүртэл хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлсэн. Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар тусгай бүлэг заалтыг оруулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цалин хангамж нэмэгдэж компанийн бага тушаалын албан хаагчийн цалингийн хэмжээнд хүртэл хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлсэн.

Эрчим хүчний яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Эрчим хүчний салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт байгууллагууд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудалд төсөв батлуулан ажиллаж байна.

Эрчим хүчний салбарын 2019-2020 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтад заасны дагуу үйлдвэрлэлийн ослоор амь эрсэдсэн, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн ослоор групп тогтоолгосон болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүндэтгэл үзүүлэх ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан.

Мөн салбарын байгууллагууд энэ ажлын хүрээнд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр группэд байдаг иргэдэд 250,000-500,000 хүртэлх төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгов. Түүнчлэн үйлдвэрлэлийн осолгүй ажиллах уриалга гарган компанийн урсдаг электрон самбарт санамж уриалгуудыг байрлууллаа.

## ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх үүднээс газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/60 тоот тушаалаар орон тооны бус дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Тус дэд зөвлөл нь 2019 онд хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн, ялангуяа цахим хуудас болон өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн ажилласан.

Тус дэд зөвлөлөөс “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах журам”-ын дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага”-ыг шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Мөн дэд зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах зорилгоор хөгжлийн бэрхшээл ба мэдээллийн хүртээмжийн талаар ойлголт, мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, нийгмийн оролцоог сайжруулахын тулд мэдээллийн түгээмэл эх сурвалж болох цахим хуудасны хүртээмжтэй байдал, тэр дундаа төрийн байгууллагын цахим

хуудасны хүртээмжтэй байдлыг хангаснаар хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулахад төдийгүй төрөөс хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны биелэлт хангагдахад томоохон түлхэц болох юм.

Энэ хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний цахим хуудасны хүртээмжийг сайжруулах олон улсын аргачлал, стандартыг (Web Content Accessibility Guidelines) Монгол хэлээр орчуулаад байна. Энэхүү олон улсын аргачлалын дагуу төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зорилгоор «Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээллийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай» Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулаад байна.

Энэ ажлын дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудын идэвх оролцоотойгоор төрийн байгууллагын цахим хуудасны, цаашлаад томоохон мэдээллийн сайтуудын хүртээмжийг сайжруулах, хүртээмжтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ, телевизийн контентыг нэмэгдүүлэх, тусгай хэрэглээний програм хангамж, аппликейшн хөгжүүлэх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн шат дараалсан тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм.



## **АРАВДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР**

1. “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” (DPUB)

Төслийн хугацаа: 2016.05.31-2020.05.30

Санхүүжүүлэгч: Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)

Төслийн хамрах хүрээ: Улаанбаатар хот

Төслийн зорилго: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дэмжих, тогтолцоог сайжруулах.

Үр дүн 1: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн санг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр бүрдүүлэх;

Үр дүн 2: Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх;

Үр дүн 3: Улаанбаатар хот дахь дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийг сайжруулах нөөцийг бүрдүүлэх;

Үр дүн 4: ХБИ-ийн нийгмийн оролцоог хангах чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чадавхийг бэхжүүлэх.

### Өнөө хүртэлх гол үйл ажиллагаа, үр дүн

-Тус төсөл нь Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт (DET-ыг зохион байгуулахад анхаарлаа хандуулж ирсэн. 2019 оны 12 дугаар сар хүртэл 46 сургагч багш, 11 ахлах сургагч багш, 3 трэйнэр бэлтгэгдсэн. 2019 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар, төр болон хувийн хэвшлийн байгууллага, ТББ-уудад 306 удаагийн сургалтыг зохион байгуулж, оролцогчдын нийт тоо 10,140 хүрсэн байна. Ингэснээр дэлхийн хэмжээнд уг сургалтад хамгийн олон хүнийг хамруулсан орноор тодроод байна.

-Дэд бүтцийн хүртээмж сайжруулах чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 2016 оны 08 дугаар сараас төрийн болон үйлчилгээний байгууллагуудаар хүртээмжийн үнэлгээ хийж эхэлсэн. Түүнчлэн 2017 оны 3 дугаар сард Японоос мэргэжилтэн урьж ирүүлэн хүртээмжийн тухай семинар зохион байгуулж, бие даан үнэлгээ хийх аргад нийт 65 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургасан.

-Шинэ нисэх онгоцны буудал болон нийслэлийн 9 дүүргийн төрийн үйлчилгээ, олон нийтийн үйлчилгээний байгууллагуудын дэд бүтцийн хүртээмжийг үнэлэх зэргээр төр засгийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Зөвхөн үнэлгээ хийх нь дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад хангалттай биш гэдэг нь үйл ажиллагааны үр дүнгээр харагдаж байна.

-Ялангуяа, “Барилгын зөвшөөрөл олгох тогтолцоо” болон холбогдох байгууллагуудад ажиллагчид, ялангуяа, барилгын компанийн удирдлага, инженер, төсөвчин, архитекторын мэдлэг ойлголттой хангалтгүй байгаа нь үүний нэг томоохон шалтгаан гэж хэлж болно. Тиймээс дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахын тулд 2019 онд Япон улсад холбогдох байгууллагын төлөөлөл бүхий багийн сургалт, Монгол Улсад цуврал семинаруудыг дээрх төлөөллүүдийн оролцуулан зохион байгуулсан юм.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон төрийн албан хаагчдыг чадавхжуулах хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй залуу манлайлагчийг бэлтгэх сургалтыг 6, Хөгжлийн бэрхшээлийн талаарх цуврал сургалтыг 18 удаа тус тус зохион байгуулж, давхардсан тоогоор 1000 гаруй хүнийг хамруулаад байна. 2019 онд өнөөг хүртэлх Хөгжлийн бэрхшээлийн талаарх цуврал сургалт Энгийн болон Мэргэжлийн ангиар зохион байгуулж байна. Энгийн ангийг амжилттай төгссөн оролцогчдыг мэргэжлийн ангид өөрсдийнх нь хүсэлтээр элсүүлж, үргэлжлүүлэн хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр өндөр мэдлэг, туршлагатай болгох, хүний нөөцийг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх зорилгоор сард нэг удаа (10 удаагийн цуврал) зохион байгуулсан. Тус ангийг амжилттай төгссөн 14 хүнд сертификат гардуулан өгсөн.Түүнчлэн Япон улсад зохион байгуулагдсан “Сэдэвчилсэн сургалт”-д ТББ-ын төлөөлөл 8 хүн, төрийн байгууллагын 3 хүнийг, “Багийн сургалт”-д ТББ-ын төлөөлөл 24 хүн, төрийн байгууллагын 34 хүнийг тус тус хамруулаад байна. (Хүснэгт 16)

-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөл болон яамдын дэргэдэх дэд зөвлөлийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх сургалтыг 2019 оны 5, 11 дүгээр сард зохион байгуулж, НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц болон Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад дэд зөвлөлийн үүрэг оролцоо, тулгамдаж байгаа асуудал, цаашдын төлөвлөгөөний талаар санал солилцлоо.

-Төрөөс хөгжлийн бэрхшээлийн салбарт авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, Бодлого үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах” (цагаан ном)-ыг боловсруулан, хэвлэж гаргахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж байна. 2018 оны 3 дугаар сард анхны мэдээллийн лавлах (цагаан ном), 2019 онд 2 дахь дугаарыг хэвлэн гаргасан бөгөөд 2020 онд 3 дахь дугаарыг бэлтгэн гаргалаа. Мөн хөгжлийн бэрхшээлийн салбарын мэдээллийн санг сайжруулах зорилгын хүрээнд хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик судалгаатай холбоотой ажилд зөвлөгөө өгч ажиллаж байна.

Хүснэгт 16 : Япон дахь сургалтын сэдэв ба оролцогчдын тоо

<b>Сэдэвчилсэн сургалт</b>		
2016 он 9-12 сар	Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх болон сүлжээ	ХБИ 1 хүн
2017 он 1-3 сар	Оюуны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх бүс нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа	ХБИ 1 хүн
2017 он 6-7 сар	Бүх хүмүүст ээлтэй орчны хүртээмжийг сайжруулах – Саадгүй орчныг бий болгох тухай	ХБИ 1 хүн, Төр 1 хүн
2017 он 9-11 сар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч залуусын чадавхийг бэхжүүлэх	ХБИ 1 хүн
2018 он 2-3 сар	Оюуны болон Хөгжлийн хоцрогдолтой иргэдэд үзүүлэх бүс нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа	ХБИ 1 хүн
2019 он 8-9 сар	Хамт олонд түшиглэн хамруулах аргачлалаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо, амьжиргааг дэмжих	ХБИ 1 хүн, Төр 2 хүн
2020 он 1-2сар	Оюуны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх бүс нутгийн дэмжлэг ба үйл ажиллагаа	ХБИ 2 хүн
<b>Багийн сургалт</b>		
2017 он 2 сар	Японы ХБ-н халамжийн тогтолцоо болон бодлого, дэд зөвлөлийн тухай	ХБИ-ийг дэмжих ТББ 3 хүн, Төр 7 хүн
2017 он 7-8 сар	Хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо баримт ба судалгаа	ХБИ-г дэмжих ТББ 2 хүн, Төр 8 хүн
2017 он 12 сар	Хөгжлийн бэрхшээлтэй манлайлагч бэлтгэх сургалт	ХБИ-г дэмжих ТББ 5 хүн, Төр 1 хүн
2019 он 1-2сар	Хөгжлийн бэрхшээлийн салбарын манлайлал бэлтгэх	ХБИ 5 хүн, Төр 5хүн
2019 он 5-6сар	Дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах	ХБИ 3 хүн, Төр 7хүн, Их сургуулийн багш 1
2020 он 1сар	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь	ХБИ 6 хүн, Төр 5 хүн



Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн семинар



Хөгжлийн бэрхшээлийн тухай цуврал хичээл

Төслийн цахим хуудас

Япон хэл дээр <https://www.jica.go.jp/project/mongolia/015/index.html>

Монгол хэл дээр <https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/015/index.html>

Англи хэл дээр <https://www.jica.go.jp/project/english/mongolia/015/index.html>

Төслийн Facebook (Япон Монгол) <https://www.facebook.com/jicadpub/>

## 2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”

### ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ:

Төсөл хэрэгжих хугацаа: 2018.04.30-2022.10.31

Санхүүжүүлэгч байгууллага: Азийн хөгжлийн банк

Хэрэгжүүлэгч байгууллага: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Төслийн хамрах хүрээ: Улаанбаатар хот, 6 аймаг /Дорнод, Ховд, Дархан-Уул, Хөвсгөл, Архангай болон Дундговь/

### ЕРӨНХИЙ ТОЙМ

Монгол Улсын Засгийн газар Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг 2022 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд энэхүү төсөл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой.

Төсөл нь (i) хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхыг бэхжүүлж, тогтолцоог бүрдүүлэх, (ii) ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, (iii) орчны хүртээмжийг сайжруулах, (iv) ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах, (v) ХБИ-ийг дэмжих стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тус төслийн үндсэн хэрэгжүүлэгч бөгөөд Эрүүл мэндийн яам бүрэлдэхүүн I хэсгийн үйл ажиллагаа, үр дүнд бүхэлд нь, бүрэлдэхүүн II-V хэсгийн үйл ажиллагаа, үр дүнд хэсэгчилсэн байдлаар дэмжлэг үзүүлэн ажиллана.

### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

Төслийн бүрэлдэхүүн I хэсгийн хүрээнд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг эрт оролцооны тогтолцоог бүрдүүлэх, чадавхийг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн сэргээн засах, хөгжлийг дэмжих үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажил 2019 оны 05 дугаар сард эхэлж, 2019 оны 12 дугаар сард “Эм Си Ди Эс” Консалтинг ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зөвлөх компанийг сонгон шалгаруулах ажлыг 2019 оны 11-12 дугаар сард зохион байгуулж, 2020 оны 3 дугаар сард шалгарсан компанитай гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх техникийн 5 ажлын хэсгийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/382 болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн А/04/А/27 тушаалаар тус тус байгуулсан. Техникийн ажлын хэсгүүдэд нийт 74 төрийн болон төрийн бус байгууллагууд, ХБИ-ийн төлөөлөл 100 гаруй гишүүд ажиллаж эхлээд байна. Ажлын хэсгүүд нь төслийн хүрээнд ажиллах гадаад, дотоодын зөвлөх компани болон хувь зөвлөхүүдийн гүйцэтгэсэн ажлын тайлан, баримт бичигтэй танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын гүйцэтгэлийг үнэлэн санал дүгнэлт гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулж, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

Төслийн олон талт хамтын ажиллагаа, оролцоог хангах төлөвлөгөөг оролцогч талуудын зорилго, хамрагдах шалтгаан, оролцох арга хэлбэр, хариуцах этгээд, хугацааны шинжилгээнд үндэслэн АХБ-ны аргачлалд нийцүүлэн боловсруулж, ХНХ-ын сайдын 2020 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн А/03 тушаалаар батлуулан ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөө нь ХБИ-ийн эрхийг хамгаалах, үйлчилгээг хүргэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, нутгийн захиргааны байгууллагууд, эмнэлгүүд, их сургуулиуд, хөдөлмөрийн эрхлэлтийн төрийн болон хувийн байгууллагууд, ХБИ-ийн байгууллагууд, ажил олгогчид, хувийн хэвшил зэрэг нийт 41 байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж байна.

Архангай, Дундговь, Дорнод, Дархан-Уул, Ховд, Хөвсгөл аймагт барих хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв, Улаанбаатар хотноо барих төвийн барилгын зургийг боловсруулах ажлын даалгаврын төслийг боловсруулан тендер зарласан. Гэрээ байгуулах зөвшөөрөл авах шаардлагатай байсан ч тендерт оролцогч байгууллага АХБ-нд хандан гомдол гаргасан. Иймд АХБ-наас тендерийн үйл ажиллагааг хүчингүй болгож, ажлын даалгавар болон тендерийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр богино жагсаалтад орсон компаниудыг дахин тендерт оролцуулах чиглэл ирүүлсэн. Үүний дагуу ажлын даалгаврыг дахин шинэчлэн боловсруулаад АХБ-аас зөвшөөрөл авахаар хүргүүлээд байна. Барилгын ажлыг 2020 оны 9 дүгээр сараас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Батсүмбэр дэх ахмад настны үндэстний төвд 364.0 сая төгрөгийн үнэ бүхий шаардлагатай туслах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.

Дэлхийн Залуучуудын 5 дугаар чуулга уулзалтад нийслэл болон орон нутгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцоход 26.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн 2019 оны 12 дугаар сарын 03-ны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдөр зохион байгуулагдсан "Хүртээмжтэй Ирээдүй - 2019" өдөрлөг, 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан аймаг, дүүргүүдийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар дах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалт зохион байгуулахад тус тус дэмжлэг үзүүлэн ажилласан.

#### ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЦААШИД ХИЙГДЭХ АЖЛУУД

-Эрт илрүүлэх ур чадварыг хөгжүүлж, хөгжлийг бэрхшээлийг тогтоох эмнэлгийн аргачлалаас нийгмийн загварчлалд шилжихэд дэмжлэг үзүүлнэ.

-Архангай, Дундговь, Дорнод, Дархан-Уул, Ховд, Хөвсгөл аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөгжлийн төвийг байгуулна.

-Орчны хүртээмж (дэд бүтэц, тээвэр, мэдээлэл)-ийн талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, лавлагаа тусламжийн шууд утсыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт ажиллуулна.

-Хэл засалч, хөдөлгөөн засалч, хиймэл эрхтний техникч, нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөрийг бэлтгэн холбогдох их дээд сургуульд нэвтрүүлэх замаар хөгжлийн бэрхшээлийн салбарын боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.

-Хиймэл эрхтэн, туслах хэрэгслийн хүртээмжийг сайжруулах, чиглэсэн дүрэм журмыг боловсронгуй болгож, протез ортопедийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

-Үйл хөдлөлийн олон улсын ангиллыг Монгол Улсад нэвтрүүлнэ.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тодорхой аж үйлдвэрийн чиглэлээр ур чадварыг нь дээшлүүлэх, ажлын байраар хангах болон ажилд зуучлах шинэ загварыг бий болгон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх төвийг барьж үйл ажиллагааг эхлүүлнэ.

-Хөгжлийн бэрхшээлийн талаарх статистик мэдээллийг сайжруулна.

### 3. БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төслийн талаар

#### А. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв төсөл”

БНХАУ-ын тусламжаар Монгол Улсад баригдаж буй “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийн төсөл нь БНХАУ-аас Монгол Улсад үзүүлж байгаа тусламжийн ажлуудын хамгийн том хүмүүнлэгийн төсөл юм.

Барилгыг 2019 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар хүлээн авсан бөгөөд Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 125 дугаар тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийг байгуулж, дүрмийг баталлаа.

Төв ашиглалтад орсноор 189 ажлын байр шинээр бий болсон бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар 170 хүн ажиллаж байгаагийн 18 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хооронд байгуулсан 2018 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн солилцох захидал болон 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дагалдах байгууламжийн төслийг хэрэгжүүлэх гэрээний дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дагалдах байгууламжийн төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Тус дагалдах байгууламжийн төслийн хүрээнд сэргээн засах эмчилгээ ба яаралтай тусламжийн зориулалттай 169 нэр төрлийн тоног төхөөрөмж авна. Түүнчлэн төвийн барилгын нүүр талд дээвэрт байрлуулсан гадна талын гэрэлтдэг хаягжилт, төв замтай холбосон гүүрэн орц гарц, төвийн хашаан доторх ногоон байгууламж зэрэг тохижилтын ажил хийгдэх юм.

Төвийн гадна нарс, хус, хайлаас, хайтан, бүйлс, гүйлс зэрэг 660 ширхэг мод тарьж, 1200 м<sup>2</sup> спорт талбайн суурийн ажил хийгдээд байна.

Эдгээр ажлаас гэрээний дагуу барилгын орц, гарцын зураг төслийг холбогдох байгууллагаар баталгаажуулж, 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс гүйцэтгэлийн ажил эхэлсэн.

#### Б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын төсөл

Мөн БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 20.4 сая ам долларын өртөгтэй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спорт цогцолборын ордон” барих ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Тус спорт цогцолбор ордон нь нийтдээ 19,567.0м<sup>2</sup> талбай бүхий зоорьтой 7 давхар барилга бөгөөд зочид буудал, 200м тойрог бүхий манеж, гадна талдаа 400м тартан зам, 200 ортой тамирчдын байрлах байр, 150 хүн зэрэг хооллох хоолны газар, хурлын танхим, заалны тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн явуулах спорт заал, фитнес заал, жудо бөх, хүндийн өргөлт, таеквандо, сагсан бөмбөг, суугаа волейбол, ширээний теннис, хөнгөн атлетик, байт харваа, хонхот бөмбөг, буудлага зэрэг пара спортын 10 төрөлд зэрэг хичээллэх боломжтой бэлтгэлийн заалтай олон улсын стандартад нийцсэн тусгай тоноглол бүхий ордон байна.

Тус ордонг Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Чингис Хаан ОУ-ын Нисэх буудлын нисэх, буух зурвасын баруун талд 10 га газарт барихаар төлөвлөж байна. БНХАУ-ын талаас судалгааны ажлын хэсэг Монгол Улсад 2019 оны 4-5 дугаар саруудад 40 гаруй хоног ажилласан. Ажлын хэсэг барилгын ажлын зургийг зурахад шаардлагатай бүхий л судалгааг хийсэн бөгөөд үр дүнд зургийн ажлын тендер БНХАУ-д зарлагдан гүйцэтгэгч барилгын зургаа зурж эхлээд байна.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж**

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

##### **4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

4.1.5. “хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.6. “боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээ;

4.1.7. “урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.8. “туслах хэрэгсэл” гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах,

- хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;
- 4.1.9. “асаргаа сувилгааны хэрэгсэл” гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;
- 4.1.10. “ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг;
- 4.1.11. “бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;
- 4.1.12. “хөтөч нохой” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;
- 4.1.13. “дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонголт, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг.

### **5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим**

- 5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална:
- 5.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;
- 5.1.2. хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх;
- 5.1.3. сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.1.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх;
- 5.1.5. хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх;
- 5.1.6. хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАРИЛЦААНД ТЭГШ ОРОЛЦОХ ЭРХ**

#### **6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах**

- 6.1. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 6.2. Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.
- 6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:
- 6.3.1. нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх;
- 6.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;
- 6.3.3. хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах;
- 6.3.4. хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- 6.3.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;
- 6.3.6. төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.
- 6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:
- 6.4.1. ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад

тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;

6.4.2.хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3.байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсадыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4.гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5.хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.

6.5.Дараахь үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.2.гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;

6.5.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

## **7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх**

7.1.Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

7.1.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого хэрэгжүүлэх;

7.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулан холбогдох зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын оролцоог хангана.

7.3.Энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг зохион байгуулах ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалдаг байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлж болох ба холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргана.



## ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ АЖИЛЛАЖ АМЬДРАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### **8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**

8.1. Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

8.2. Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

8.3. Төрийн байгууллага нь нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба холбогдох зардлыг улсын төсөвт тусгана.

8.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

### **9 дүгээр зүйл. Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

9.1. Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

9.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

9.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

9.4. Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

9.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.

### **10 дугаар зүйл. Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

10.1. Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

10.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

10.3. Нийтийн тээврийн байгууллага энэ хуулийн 10.2-т заасан стандарт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах үүрэгтэй.

### **11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

11.1. Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах

боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;

11.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох;

11.2.3.ном, сурах бичиг, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэрэг бүх төрлийн хэвлэмэл материалыг хүртээмжтэй ашиглахад зориулсан бар кодтой хэвлэх;

